

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН  
ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ НЭГТГЭСЭН ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛ, САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН  
ТАЙЛАН**

Аудитын код: СЭА/2018/01/СТА-ТЕЗ

**Сүхбаатар сум  
2018 оны 04 дүгээр сар**

<p><b>Тайланг бэлтгэсэн:</b>  <b>Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар</b></p> <p><b>Дарга, тэргүүлэх аудитор:</b>  <i>Ч.Энхтуяа</i></p> <p><b>Аудитын менежер:</b>  <i>Б.Батмөнх</i></p> <p><b>Ахлах аудитор:</b>  <i>С.Бат-Эрдэнэ</i>  <i>С.Баасансүрэн</i></p> <p><b>Аудитор:</b>  <i>Б.Эрдэнэзул</i>  <i>Ц.Отгонбаяр</i>  <i>Ц.Уртнасан</i>  <i>А.Дашбат</i>  <i>Э.Эрдэнэзул</i>  <i>Ж.Цогт</i></p> <p><b>Уг тайланг УАГ-ын Цахим хуудаснаас үзнэ үү:</b>  <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p><i>Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7036-3040, 7036-3047, 7036-2442, 7036-3036 дугаарын утас, <a href="mailto:www.Selenge@audit.gov.mn">www.Selenge@audit.gov.mn</a> цахим хаягаар харьцана уу</i></p> <p><b>ХАЯГ:</b></p> <p><b>ТАБ-ын хаяг:</b> Сэлэнгэ аймаг Дахь Төрийн Аудитын газар  <b>Байршил:</b> АЗДТГ-ын байрны өргөтгөлд  <b>2018 оны 4 дүгээр сар</b></p>	<p>Товчилсон үгийн тайлбар.....5</p> <p><b>Аудитын талаарх үндсэн мэдээлэл</b></p> <p>Аудит хийсэн үндэслэл, хугацаа.....6          Аудитын зорилт, хамарсан хүрээ.....6          Аудитын арга зүй.....6          Материаллаг байдлын түвшин.....6</p> <p><b>Санхүүгийн тайланг нэгтгэхэд баримталсан зарчим, аргачлал</b> .....7-8</p> <p>Санхүүгийн тайланг бэлгэсэн суурь .....7          Тайланг илэрхийлсэн мөнгөний нэгж .....7          Санхүүгийн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн ..... 7-8</p> <p><b>Нягтлан бодох бүртгэлийн зарчим</b>.....8-12</p> <p>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө ..... 8          Авлага ..... 8          Урт хугацаат зээлийн авлага ..... 8          Бараа материал ..... 8          Үндсэн хөрөнгө ..... 9          Биет бус хөрөнгө ..... 9          Богино хугацаат өр төлбөр ..... 9          Урт хугацаат өр төлбөр ..... 9          Орлого хүлээн зөвшөөрөлт ..... 9          Зардал ..... 9          Дотоод аудит .....9-11          Шилэн дансны мэдээлэл .....11-12</p> <p><b>Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэл тайлангийн тодруулга, аудитын дүн</b> .....12-36</p> <p><b>Нэг. Мөнгөн хөрөнгийн бүртгэл тайлагнал</b></p> <p>1.1 Мөнгөн хөрөнгийн бүтцийн талаар.....12-13          1.2 Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой гарсан зөрчлийн талаар ..... 13</p> <p><b>Хоёр. Авлагын бүртгэл, тайлагнал</b></p> <p>2.1. Авлагын бүтэц, бүрэлдэхүүний талаар.....13-14          2.2.Авлагын данстай холбоотой гарсан зөрчлийн талаар... 14</p> <p><b>Гурав. Бараа материалын бүртгэл, тайлагнал</b></p> <p>3.1. Бараа материалын бүтэц, бүрэлдэхүүний талаар.....14-15          3.2 Бараа материалын данстай холбоотой гарсан зөрчлийн талаар.....15</p> <p><b>Дөрөв. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал</b></p> <p>4.1. Үндсэн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүний талаар.....15-16</p>
---	---

4.2 Үндсэн хөрөнгийн дансантай холбоотой гарсан зөрчлийн талаар.....	16
<b>Тав. Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал</b>	
5.1. Өр төлбөрийн бүтцийн талаар.....	16-17
5.2.Өр төлбөрийн дансантай холбоотой гарсан зөрчлийн талаар .....	17
<b>Зургаа. Орлогын бүртгэл, тайлагнал</b>	
6.1. Төсвийн орлого санхүүжилтийн талаар.....	18
6.1.1. Татварын болон татварын бус орлогын талаар .....	18-20
6.2.Орлогын данстай холбоотой гарсан зөрчлил .....	20-21
<b>Долоо. Зардлын бүртгэл, тайлагнал</b>	
7.1. Аймгийн төсвийн нийт зардлын талаар.....	21-22
7.1.1 Орон нутгийн төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийн талаар .....	22
7.1.2 Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн зардлын гүйцэтгэлийн талаар .....	23
7.2.Зардлын данстай холбоотой гарсан зөрчлийн талаар.....	23
7.2.1 Цалингийн зардлын гүйцэтгэлтэй холбоотой илэрсэн алдаа, зөрчлийн талаар.....	24
7.2.2 Бусад зардлын гүйцэтгэл болон бүртгэл тайлагналтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар.....	24-27
7.2.3 НДШ, ХХОАТ, НӨАТ-ын бүртгэл тайлагналтай холбоотой гарсан алдаа зөрчлийн талаар.....	27
7.2.4 Замын сан, хөрөнгө оруулалтын барьцааны дансны талаар.....	27
7.2.5 Орон нутгийн хөрөнгө оруулалт, түүний гүйцэтгэлтэй холбогдон гарсан зөрчлийн талаар.....	27-28
7.2.6 Орон нутгийн хөгжлийн сангийн талаар.....	29
<b>Найм. ТЕЗ-ийн тайланд нэгтгэгдсэн төсөл, сангийн талаар.....</b>	
<b>29</b>	
8.1. Төсөл, сангуудын санхүүгийн тайланд илэрсэн алдаа, зөрчлийн талаар.....	29-30
<b>Ес. Аймаг, сумын орон нутгийн төсвийн байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар.....</b>	
<b>30</b>	
<b>Арав. Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих төсвийн байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар.....</b>	
<b>30-31</b>	
<b>Арван нэг. Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар .....</b>	
<b>31-32</b>	
<b>Арван хоёр. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар .....</b>	
<b>32</b>	
<b>Арван гурав. Анхаарал татахуйц бусад чухал асуудал .....</b>	
<b>32-34</b>	
<b>Арван дөрөв. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....</b>	
<b>34</b>	
<b>Арван тав. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....</b>	
<b>34</b>	

Арван зургаа. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт.....	34-35
Арван долоо. Аудитын зөвлөмж.....	35
Арван найм. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт .....	35-36

**Хавсралтууд:**

1. Менежментийн захидал
2. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан
3. Аудитаар илэрсэн зөрчлийн дэлгэрэнгүй хавсралтуууд
4. Албан шаардлага

## Товчилсон үгийн тайлбар

БСШУСС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
ГХБХБГ	Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газар
ГИХГ	Гадаадын иргэн харьяатын газар
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗДН	Засаг даргын нөөц
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУ	Монгол Улс
МСҮТ	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СТОУС	Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт
СХС	Сум хөгжүүлэх сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ТЭДС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМТ	Эрүүл мэндийн төв

## **АУДИТЫН ТАЛААРХ ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ**

### **Аудит хийсэн үндэслэл, хугацаа:**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв. СЭА/2018/01-СТА-ТЕЗ

### **Аудитын зорилт, хамарсан хүрээ:**

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг УСНББОУС, СТОУС болон бусад шаардлагын дагуу бэлтгэж, ажил гүйлгээ нь түүнийг зохицуулж буй хууль, тогтоомжийн хүрээнд хийгдэн, үнэн шударга илэрхийлэгдсэн эсэх үндэслэлтэй баталгаагаар дээд шатны төсвийн захирагч болон хэрэглэгчдийг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангууд иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгыг тэдгээр тайланд хавсаргах ёстой. Эдгээр мэдээллийг Аудитын олон улсын стандартын дагуу сорьж шалгах нь аудитын зорилт бөгөөд хамарсан асуудлууд болно.

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар аймгийн ТЕЗ-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, санал дүгнэлт гаргахын өмнө Төсвийн тухай болон Төрийн аудитын тухай хуулийн дагуу төсвийн захирагчид, тусгай сан, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн 2017 оны санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан болно.

### **Аудитын арга зүй:**

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг үндсэн шалгуур болгон хяналтын сорил, шинжилгээний горим болон нарийвчилсан сорил гүйцэтгэж, түүврээр ажил гүйлгээ, тооцооллыг давтан шалгаж, үнэлгээ өгөв.

### **Материаллаг байдлын түвшин:**

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд төсөвт байгууллага, төрийн сан, төсөл сан, болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлангууд нэгтгэгддэг тул материаллаг байдлын түвшинг Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын дүнгийн 2 хувь буюу 1,833.0 сая төгрөгөөр тогтоосон болно.

## **САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН ЗАРЧИМ, АРГАЧЛАЛ**

Сэлэнгэ аймгийн ТЕЗ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн дагуу 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэн гаргаж, хуульд заасан хугацаанд Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд:

- *Сумдын төсвийн төвлөрүүлэн захирагчдын 17 санхүүгийн нэгтгэсэн тайлан;*
- *Орон нутгийн төсвийн шууд захирагчдын 51 санхүүгийн тайлан,*
- *Аймаг, сумдын орон нутгийн ерөнхий орлогын 18 санхүүгийн тайлан,*
- *Аймаг, сумдын орон нутгийн зардлын дансдын 22 санхүүгийн тайлан,*
- *Улсын төсвийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын 135 санхүүгийн тайлан,*
- *Төсөл сангийн 18 санхүүгийн тайлан,*
- *Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн 17 санхүүгийн тайлан зэрэг нийт 278 санхүүгийн тайланг нэгтгэсэн байна.*

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас сумдын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 17 санхүүгийн нэгтгэсэн тайлан, аймаг, сумдын ерөнхий орлогын болон зардлын дансдын 30, санхүүгийн тайлан, орон нутгийн төсвийн байгууллагын 46, тусгай зориулалтын шилжүүлгийн 135 байгууллага, төсөл сангийн 18, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын 13 байгууллагын зэрэг нийт 261 санхүүгийн тайланд аудит хийж, 79 санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулан дүнг төсвийн төвлөрүүлэн болон ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайланд тусгаж, нийт 190 санхүүгийн тайланд бие даасан дүгнэлт гаргасан байна.

Сумдын төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 12 сумын нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт, Хүдэр, Хушаат, Орхонтуул, Шаамар, Ерөө сумдын нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгөв.

Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн болон төсвийн шууд захирагч нарын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 135 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт, 37 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт, 2 байгууллагын санхүүгийн тайланд “Сөрөг” санал дүгнэлт өгч, 1 байгууллагын санхүүгийн тайланд санал, дүгнэлт өгөхөөс татгалзсан байна.

МУ-ын Ерөнхий аудиторын тушаалаар 5 сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд итгэл үзүүлж “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн бол, тайланд онд огт үйл ажиллагаа явуулаагүй 4 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын санхүүгийн тайланд аудит хийгдээгүй болно.

### **Санхүүгийн тайланг бэлтгэсэн суурь:**

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг нягтлан бодох бүртгэлийн тохируулсан аккруэл суурийг хэрэглэж бэлтгэсэн байна.

### **Тайланг илэрхийлсэн мөнгөний нэгж:**

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалтын дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлж, санхүүгийн нэгтгэсэн тайлан болон тодруулга тайланг мянган төгрөгөөр илэрхийлсэн байна.

### **Санхүүгийн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн:**

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулсан Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дараах бүрэлдэхүүнтэй байна.

А. Үндсэн тайлан:	Б. Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан	В. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тайлбар, тодруулга
Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн байдлын тайлан	НББ-ийн бодлого, зарчим
Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн үр дүнгийн тайлан	Толилуулгын суурь
Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх мөнгөн гүйлгээний тайлан	
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	

Дээрх санхүүгийн байдлын, санхүүгийн үр дүнгийн, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлангуудыг Сангийн яамны “**е-тайлан**”-д нэгтгэн бүртгэж, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна. Тус програм нь нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандарт, заавар, журамтай нийцсэн байна.

#### **Нягтлан бодох бүртгэлийн зарчим:**

#### **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө**

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь дараах зүйлсээс бүрдсэн байна. Үүнд:

- Төрийн сангийн нэгдсэн дансан дахь аймаг, сумдын төрийн сангийн дансны үлдэгдэл;
- Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн арилжааны банк дахь үлдэгдэл;
- Касст байгаа бэлэн мөнгө;

Мөнгө ба түүнтэй адилтгах мөнгөн хөрөнгө нь богино хугацаанд, өндөр хөрвөх чадвартай, үнэ цэнээ алдах эрсдэл багатай хөрөнгө байна.

#### **Авлага**

Авлага нь богино хугацаат дансны авлага, зээлийн авлага болон урьдчилгаанаас бүрдэнэ.

#### **Урт хугацаат зээлийн авлага**

Урт хугацаат зээлийн авлага нь аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын бусдад нэг жилээс дээш хугацаанд зээлдүүлсэн мөнгөн хөрөнгийн жилийн эцэст төлөгдөөгүй байгаа үлдэгдэл дүнг илэрхийлнэ. Зээлийн авлагыг төлөгдөх дүнгээр нь хүлээн зөвшөөрсөн байна.

#### **Бараа материал**

Бараа материалын өртгийг эхэлж авснаа эхэлж зарлагдах аргаар тодорхойлжээ.

#### **Үндсэн хөрөнгө**



Үндсэн хөрөнгийг өртгөөр нь болон Сангийн сайдын 2009 оны 135 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн дахин үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу төсөвт байгууллагын үндсэн хөрөнгийг дахин үнэлсэн дүнгээр хүлээн зөвшөөрсөн.

Төсвийн захирагчид 2017 онд үндсэн хөрөнгөд УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө” стандартын дагуу элэгдэл байгуулжээ.

### **Биет бус хөрөнгө**

Биет бус хөрөнгө гэдэг нь биет шинж чанаргүй боловч ирээдүйд түүнээс өгөөж хүртэхийн тулд гаргасан зарлага юм.

### **Богино хугацаат өр**

Богино хугацаат өр төлбөр нь нэг жилийн дотор барагдуулах ёстой өр төлбөрийг илэрхийлнэ.

### **Урт хугацаат өр төлбөр**

Урт хугацаат өр төлбөр гэдэг нь нэг жилээс дээш хугацаанд барагдуулах үүрэг хариуцлага юм.

### **Орлого хүлээн зөвшөөрөлт**

Арилжааны бус орлого болох татвар, хураамж, торгууль, шимтгэлийг цуглуулсан үед, төсвийн санхүүжилтийг харилцах дансанд орж ирсэн үед нь, харин бараа, үйлчилгээг төлбөртэйгээр хүргэсэн үед арилжааны (хэрэгжсэн) орлогыг тохируулсан аккруэл сууриар хүлээн зөвшөөрсөн байна.

### **Зардал**

Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийн дагуу гарсан үед нь хүлээн зөвшөөрсөн байна.

### **Дотоод аудит:**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцын байгууллагуудын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн шатанд их гэж тооцсон бөгөөд дахин хянахад дунд байна. Аудитын явцад төлөвлөсөн горим сорилын дагуу дотоод аудитын албаны үйл ажиллагаатай танилцаж, тэдний үүрэг чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хавсаргав.

Төсвийн тухай хуулийн 69-р зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэгдсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэж

заасны дагуу аймгийн Засаг даргын 2014 оны 11-р сарын 25-ны өдрийн А/433 дугаар захирамжаар дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх “ Санхүүгийн хяналт, аудитын алба” –ыг аймгийн Засаг даргын дэргэд байгуулсан нь 2017 оны жилийн эцсийн байдлаар улсын ахлах байцаагч 1, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч 3, санхүүгийн хяналт шалгалтын мэргэжилтэн, аудитын ажилтан 2 зэрэг нийт 6 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь тайлант онд эрсдэлтэй үнэлэгдсэн болон санхүүгийн хяналт, шалгалтын стандартыг үндэслэн сүүлийн 2 жилийн хугацаанд санхүүгийн хяналт, шалгалт хийгдээгүй 90 байгууллагад өөрийн төлөвлөгөөгөөр хяналт, шалгалт хийхээр төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр их болон дунд эрсдэлтэй гэж үзсэн 70 байгууллагад санхүүгийн хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн байна.

Сангийн сайдын баталсан нэгдсэн удирдамжаар Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газар, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс, Автотээврийн үндэсний төвийн харьяа Авто тээврийн төв, Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн харьяаны байгууллагуудын шилэн дансны мэдээлэл байршуулалт, аймгийн ЗДТГ-ын СТСХ -ийн үйл ажиллагаа зэрэг 5 байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн хяналт, шалгалт, аудитыг хийсэн байна. Мөн төсвийн ерөнхийлөн захирагчийн саналаар эрүүл мэнд, боловсролын салбарын төсвийн төлөвлөлтийн байдалд аудит хийж тайланг дотоод аудитын хороогоор хэлэлцүүлсэн байна. Тус албаны 2017 онд хийж гүйцэтгэсэн хяналт, шалгалт, аудитыг нэгтгэн харуулбал:

/Хүснэгт №1/

Байгууллагын төрөл	Орон нутаг	ТЗШ	Улсын төсөв	ОНӨ	бусад	Нийт дүн
Боловсролын салбар		1				1
Эрүүл мэндийн салбар		1				1
Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, ХЭД сан			1			1
Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс, сан,			1			1
Автотээврийн үндэсний төв Сэлэнгэ салбар				1		1
Аймгийн төрийн сан	1					1
Шилэн дансны мэдээлэл байршуулалт	3					1
Орон нутгийн өмчийн газар	1					1
ОНӨААТҮГ				8		8
Мандал сум	4	4			1	9
Ерөө сум	3	9		0	1	13
Орхонтуул сум	2	6			1	9
Алтанбулаг сум	1	5			1	7
Баянгол	1	5			1	7
Жавхлант сум	1	4			1	6
Хушаат сум	1	4			1	6
ОНХС	1					1
Төлөвлөгөөт бус		5	1	1	1	8
<b>Нийт</b>	<b>19</b>	<b>43</b>	<b>3</b>	<b>10</b>	<b>8</b>	<b>83</b>

2017 онд хийсэн санхүүгийн хяналт, шалгалтаар нийт 350.5 сая төгрөгийн төлбөрийн акт, 2,156.5 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлсэн байна. Гүйцэтгэлээр хугацаа болоогүй 4.5 сая төгрөг, хүчингүй болгосон 1.7 сая төгрөгийн актаас бусад 344.6 сая төгрөгийн актыг барагдуулсан байна.

Нийт илрүүлсэн зөрчлийн 61.2 хувь нь буюу 1,543.4 сая төгрөг нь 3 улсын төсвийн байгууллагад, 38.8 хувь буюу 963.6 сая төгрөг нь орон нутгийн болон тусгай

зориулалтын шилжүүлгийн байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн нэгж зэрэг 80 байгууллагад хийсэн хяналт шалгалтаар илэрсэн байна.

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяаны байгууллагуудын 2017 санхүүгийн тайланд хийсэн аудитаар өмнөх жилүүдэд илэрч байсан алдаа зөрчлүүд давтагдан гарч, зөрчлийн хэмжээ буурахгүй байгаа нь харагдаж байна. Тухайлбал, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2015 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 7,251.0 сая төгрөгийн, 2016 онд 6,987.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч байсан бол 2017 онд 9,875.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн нь 2015 оныхоос 37.8 хувиар, 2016 оныхоос даруй 41.3 хувиар нэмэгдсэн байна. Энэ нь төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа Санхүүгийн хяналт шалгалт, аудитын албаны хяналт, шалгалтын үр нөлөө хангалтгүй байна гэж үзэхэд хүргэж байна.

Цаашид аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь их хэмжээний мөнгөний эргэлт явагддаг төсөл, хөтөлбөрүүд, хөрөнгө оруулалт, тусгай сангууд болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийж, дотоод хяналт шалгалтын үр нөлөөг сайжруулах нь зүйтэй юм.

Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс өөрийн харьяа сумдын Санхүүгийн албадын үйл ажиллагаанд дотоод хяналт хийх ажлын төлөвлөгөөний дагуу 2017 онд 9 сум, 3 тосгоны төрийн сангийн үйл ажиллагааг хяналт, шалгалтад хамруулсан байна. Уг шалгалтаар төрийн сангийн мемориалын баримт, ЗГСУМС-д хийгдсэн гүйлгээ, санхүүжилт хуваарилсан болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ гаргалт, төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийж, гарсан алдаа, зөрчилд үндэслэн зөвлөмж өгч, биелэлтийг дүгнэн ажилласан бол сумдын Санхүүгийн албадууд өөрийн сумын төсөвт байгууллагуудад дотоод хяналт хийх төлөвлөгөө гарган тус бүр 1-2 удаа хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Хэдийгээр төрийн сангийн дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа боловч зардлыг зориулалт бусаар зарцуулах, төсөвт зохицуулалт хийлгүйгээр зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулах, хөрөнгө оруулалтын санхүүжилтийг гүйцэтгэгчид гэрээний дагуу санхүүжүүлээгүй, төсвийн гүйцэтгэлийг үнэн зөвөөр тайлагнахгүй байх зэрэг алдаа, зөрчлүүд жил бүр давтагдан гарсаар байна. Иймээс цаашид дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай байна.

### **Шилэн дансны мэдээлэл:**

Шилэн дансны тухай хуульд төсвийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу явуулахаас гадна хяналт тавьж ажиллахаар заасан.

Сэлэнгэ аймгийн орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд Шилэн дансны тухай хуулийн 6.1 дэх заалт, Засгийн газрын 2016 оны 01-р сарын 11-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) хуудсанд шаардлагатай мэдээллийг тавьж ажиллаж байна.

Аймгийн хэмжээний байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд Санхүүгийн хяналт дотоод аудитын алба, аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дотоод хяналтын мэргэжилтэн нар хамтран хяналт тавьж ажилласан байна.

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-ийг 2016 оны 4-р улирал, 2017 оны 1-3 дугаар улирал хүртэлх хугацааг хамруулан шалгаж, төрийн болон орон нутгийн өмч хөрөнгийг үр ашигтай захиран

зарцуулахад төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих, мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан эсэхэд аудит хийж, дараах дүгнэлтийг өгсөн байна.

- Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн 99.6 хувь нь нийт мэдээлэл зохих мэдээллийн 80.9 хувийг мэдээлсэн байна. / Сэлэнгэ үржлийн цөм сүрэг" ОНӨААТҮГ- аас бусад /
- Аймгийн ТЕЗ-ийн харьяа 201 байгууллага шилэн дансанд мэдээлэл зохих мэдээллийн 76.4 хувийг байршуулсан байна.
- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжүүд шилэн дансны бие даасан цэс нээлгээгүй, холбогдох мэдээллийг байршуулаагүй байна.
- Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль, тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэж буй хуулийн этгээдийн 27.7 хувь нь шилэн дансанд цэс нээлгээгүй бөгөөд мэдээлэл зохих мэдээллийн 44.7 хувийг мэдээлээгүй байна.
- Аймгийн ИТХ-ын зүгээс холбогдох байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хийгдэхгүй байна.
- Аймгийн ТЕЗ-ийн зүгээс шилэн дансны үйл ажиллагаанд хийсэн дотоод хяналтаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлж, дүгнэхгүй байна.
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 62.1 хувьтай байна.

Иймд цаашид аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа хуулийн этгээдүүдийн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим санд бүрэн байршуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах, хуулийн хэрэгжилтийг бүрэн хангуулж, дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Шилэн дансны тухай хуулийн 8-р зүйлийн 8.1 дэх заалтын дагуу аймаг, сумдын ИТХ-ын зүгээс холбогдох байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хийж, үнэлэлт дүгнэлт өгч байх нь зүйтэй юм.

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА, АУДИТЫН ДҮН.

### Нэг. Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал:

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл тайлант оны эхэнд 4,815.2 сая төгрөг байсан бол 0.6 хувиар өсч оны эцэст 4,844.2 сая төгрөгөөр тайлагнагдсан бөгөөд үүний 82.2 хувь буюу 3,982.5 сая төгрөг нь төрийн сангийн бүртгэлийн дансанд байршиж байна.

#### 1.1 Мөнгөн хөрөнгийн бүтцийн талаар

/Хүснэгт №2/

(сая төгрөг)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл /2016.12.31/	Эцсийн үлдэгдэл /2017.12.31 /	Кассанд байгаа бэлэн мөнгө	Банкинд байгаа бэлэн мөнгө	
				Арилжааны банк	Төрийн сангийн нэгдсэн данс
Кассад байгаа бэлэн мөнгө	32.1	53.0	53.0		
Банкинд байгаа бэлэн мөнгө	4,783.1	4,791.2	-		
Төрийн сангийн харилцах	4,365.2	3,982.5			3,982.5
Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	-			-
Арилжааны банкинд дахь харилцах	417.9	808.7		808.7	
<b>Нийт мөнгөн хөрөнгийн дүн</b>	<b>4,815.20</b>	<b>4844.2</b>	<b>53.0</b>	<b>808.7</b>	<b>3,982.5</b>

Үүнээс байгууллагын төрлөөр харуулбал:					
Төрийн сан	2,890.1	2,989.0			2,989.0
Төсөвт байгууллага	544.1	908.3			908.3
Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж	449	861.7	53.0	808.7	
Төсөл, сангууд	932	85.2			85.2
<b>Нийт мөнгөн хөрөнгийн дүн</b>	<b>4,815.2</b>	<b>4,844.2</b>	<b>53.0</b>	<b>808.7</b>	<b>3,982.5</b>

Нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 61.7 хувийг төрийн сангийн, 1.8 хувийг төсөл, сангийн, 17.8 хувийг орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн, 18.7 хувийг төсөвт байгууллагуудын мөнгөн хөрөнгө эзэлж байна.

## 1.2 Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой гарсан зөрчлийн талаар:

Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн түвшинд хийсэн аудитаар мөнгөн хөрөнгийн данстай холбоотой нийт 42.8 сая төгрөгийн материаллаг, 71.6 сая төгрөгийн материаллаг бус зэрэг нийт 114.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна. Үүнээс аудитын явцад 2.5 сая төгрөгийн алдааг залруулж, 18.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 93.8 сая төгрөгийн зөрчилд аудитын зөвлөмж хүргүүлсэн байна. /Алдаа, зөрчлийн дэлгэрэнгүйг хавсралт № 1-т үзүүлэв/

Аудитаар анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэлд тусгасан, хандив тусламжийн орлогыг кассаар хүлээн авч зарцуулсан, мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг тооллого хийж, баталгаажуулаагүй зэрэг материаллаг шинжтэй зөрчил нийтлэг байдлаар илэрсэн байна. Үүнд:

- Анхан шатны баримтын бүрдэл дутуу нийт 39.3 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэлд тусгасан,
- Хандив тусламжийн 0.1 сая төгрөгийн орлогыг кассаар хүлээн авч зарцуулсан,
- Тайлант хугацааны эцэст 3.4 сая төгрөгийн кассын үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй,

## Хоёр. Авлагын бүртгэл, тайлагнал:

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт авлагын оны эхний үлдэгдэл 14,349.9 сая төгрөг байснаас тайлант онд 940.8 сая төгрөг буюу 6.5 хувиар буурч, оны эцэст 13,409.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна

### 2.1 Авлагын бүтэц, бүрэлдэхүүний талаар

/Хүснэгт №3/

( сая төгрөг)

Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл /2016.12.31/	Эцсийн үлдэгдэл /2017.12.31/	Өсөлт /+ / бууралт /- /	Дүнд эзлэх хувь
<b>Нийт дүн</b>	<b>14,349.9</b>	<b>13,409.1</b>	<b>-940.8</b>	<b>100</b>
Ажиллагчидтай холбогдсон авлага	22.0	26.5	4.5	0.2
Төлбөртэй йлчилгээний авлага	0.1	0.1	0.0	0.0
Татаас, санхүүжилтийн авлага	256.7	4.2	-252.5	0.0
Зээлийн хүүгийн авлага	199.9	237.6	37.7	1.8
Дансны авлага /ОНӨҮГ/	1,246.9	1,403.6	156.7	10.5
Татвар, НДШ-ын авлага /ОНӨҮГ/	104.7	82.8	-21.9	0.6
Байгууллагаас авах авлага	2,253.2	2,354.4	101.2	17.5
Хувь хүмүүсээс авах авлага	4,412.9	4,179.5	-233.4	31.1
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	1,021.4	276.8	-744.7	2.1

Хувь хүмүүст олгосон зээл	4,831.9	4,843.6	11.8	36.1
<b>Байгууллагын төрлөөр</b>				
Төрийн сан	1,060.40	315.41	-745.0	2.4
Төсөвт байгууллага	455.80	425.00	-30.80	3.2
Төсөл сан	9,448.30	4,832.10	-4,616.20	36.0
Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж	3,385.27	7,836.60	4,451.33	58.4
<b>Нийт өр төлбөрийн дүн</b>	<b>14,349.77</b>	<b>13,409.1</b>	<b>-940.7</b>	<b>100.0</b>

Нийт авлагын 36.0 хувийг төсөл, сангийн, 58.4 хувийг орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн, 2.4 хувийг төрийн сангийн, 3.2 хувийг төсөвт байгууллагын авлага тус тус эзэлж байна.

## 2.2 Авлагын данстай холбоотой гарсан зөрчлийн талаар

Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн түвшинд хийсэн аудитаар авлагын данстай холбоотой нийт 152.7 сая төгрөгийн материаллаг, 21.2 сая төгрөгийн материаллаг бус зэрэг нийт 173.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнээс аудитын явцад 18.2 сая төгрөгийн алдааг залруулж, 5.9 сая төгрөгийн зөрчилд нөхөн төлүүлэх төлбөрийн акт, 8.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 141.6 сая төгрөгийн зөрчилд аудитын зөвлөмж хүргүүлсэн байна. /Алдаа зөрчлийн дэлгэрэнгүйг хавсралт № 2-т үзүүлэв./

Аудитаар санхүүгийн тайланд авлагын үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, төсвийг зохистой удирдаагүйгээс авлага үүсгэсэн, өмнөх онуудаас дамжсан авлагад дүн шинжилгээ хийж, барагдуулах арга хэмжээ аваагүй зэрэг материаллаг шинжтэй алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнд;

- Төсвийг зохистой удирдаагүйгээс тайлант онд шинээр 42.6 сая төгрөгийн авлага үүсгэсэн,
- Санхүүгийн тайлан гаргахын өмнө 79.6 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй,
- Өмнөх оноос шилжин ирсэн 30.5 сая төгрөгийн авлагад дүн, шинжилгээ хийж, барагдуулах арга хэмжээ аваагүй,

## Гурав.Бараа материалын бүртгэл, тайлагнал:

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт бараа материалын эхний үлдэгдэл 6,040.5 сая төгрөгөөр, эцсийн үлдэгдэл 7,375.8 сая төгрөгөөр тайлагнагдаж, тайлант онд 1,335.3 сая төгрөгөөр өссөн байна.

### 3.1 Бараа материалын бүтэц, бүрэлдэхүүний талаар

/Хүснэгт №4/

(сая төгрөг)

Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл /2016.12.31/	Эцсийн үлдэгдэл /2017.12.31/	Өсөлт /+ / бууралт /-/	Дүнд эзлэх хувь
<b>Нийт дүн</b>	<b>6,040.5</b>	<b>7,375.8</b>	<b>1,335.3</b>	<b>100</b>
<b>Түүхий эд материал</b>	<b>660.6</b>	<b>866.1</b>	<b>205.5</b>	<b>11.7</b>
Тусгай зориулалттай материал	525.7	695.1	169.4	9.4
Эм боох материал	134.9	171.1	36.2	2.3
Дуусаагүй үйлдвэрлэл	0	9.8	9.8	-
Бэлэн бүтээгдэхүүн	933.3	1,058.6	125.3	14.4
<b>Хангамжийн материал</b>	<b>4,340.0</b>	<b>5,214.4</b>	<b>874.4</b>	<b>70.7</b>
Бичиг хэргийн материал	109.1	137.0	27.9	1.9
Аж ахуйн материал	2,240.30	2,665.3	425.0	36.1

Сэлбэг хэрэгсэл	527.2	619.6	92.4	8.4
Түлш, шатах тослох материал	61.7	38.3	-23.4	0.5
Барилгын засварын материал	31.1	46.4	15.3	0.6
Хүнсний материал	105.5	92.1	-13.4	1.2
Бусад хангамжийн материал	1,265.10	1,615.7	350.6	21.9
Биологийн хөрөнгө	0.00	6.9	6.9	0.1
Мал амьтад	61.9	50.6	-11.3	0.7
<b>НЭСЦИЙН БАРАА</b>	<b>44.7</b>	<b>169.4</b>	<b>124.7</b>	<b>2.3</b>
Бусад нөөц	44.7	169.4	124.7	2.3
<i>Үүнээс байгууллагын төрлөөр харуулбал:</i>				
Төрийн сан	0	0	0	0
Төсөвт байгууллага	4,246.6	5,114.2	867.6	69.3
Төсөл сан	0.0	0.0	0.0	0.0
<b>Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж</b>	<b>1,793.9</b>	<b>2,261.5</b>	<b>467.6</b>	<b>30.7</b>
Нийт бараа материалын дүн	<b>6,040.5</b>	<b>7,375.7</b>	<b>1,335.2</b>	<b>100.0</b>

Нийт бараа материалын 2.3 хувийг нөөцийн бараа материал эзэлж байна.

### 3.2 Бараа материалын данстай холбоотой гарсан зөрчлийн талаар

Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн түвшинд хийсэн аудитаар бараа материалын данстай холбоотой 11.5 сая төгрөгийн материаллаг, 688.4 сая төгрөгийн материаллаг бус зэрэг нийт 699.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 269.5 сая төгрөгийн алдааг залруулж, 8.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд албан шаардлага, 422.2 сая төгрөгийн алдаа, зөрчилд аудитын зөвлөмж хүргүүлсэн байна. /Алдаа зөрчлийн дэлгэрэнгүйг хавсралт № 3-т үзүүлэв./

Аудитаар санхүүгийн тайлан дахь бараа материалын үлдэгдлийг тооллогын бүртгэлээс зөрүүтэй илэрхийлсэн, малын хорогдлыг эмчийн акт үйлдэж, баталгаажуулалгүйгээр данснаас хассан, бараа материалын орлогыг санхүүгийн тайланд дутуу тусгасан зэрэг материаллаг алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Санхүүгийн тайлан дахь бараа материалын үлдэгдэл нь жилийн эцсийн хөрөнгийн тооллогын дүнгээс 1.7 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн,
- “Сэлэнгэ Үржлийн цөм сүрэг” ОНӨААТҮГ нь 0.7 сая төгрөгийн малын хорогдлыг акт үйлдэж баталгаажуулалгүйгээр данснаас хассан,
- Хангамжийн материалыг бараа материалын данснаас шууд зардалд бүртгэсэн 2.7 сая төгрөгийн,
- Ерөө сумын ЭМТ харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүйгээс 6.4 сая төгрөгийн эм бэлтгэн нийлүүлэгчид төлсөн төлбөрөөс дутуу нийлүүлэгдсэн,

### Дөрөв.Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал:

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 217,522.9 сая төгрөгөөр, эцсийн үлдэгдэл 236,372.5 сая төгрөгөөр тайлагнагдаж, тайлант онд 18,849.6 сая төгрөгөөр өссөн байна.

### 4.1 Үндсэн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүний талаар

/Хүснэгт №5/

(сая төгрөг)

Дансны нэр, төрөл	Эцсийн үлдэгдэл /2016.12.31/	Эцсийн үлдэгдэл /2017.12.31/	Өсөлт /+ / бууралт /-/	Дүнд эзлэх хувь
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>217,522.9</b>	<b>236,372.5</b>	<b>18,849.6</b>	<b>100.0</b>
<b>Биет хөрөнгө</b>	<b>216,695.8</b>	<b>235,540.6</b>	<b>18,844.8</b>	<b>99.6</b>
Барилга, байгууламж, орон сууц	166,132.1	178,902.2	12,770.1	75.7



Авто-тээврийн хэрэгсэл	6,471.7	7,068.3	596.6	3.0
Машин тоног төхөөрөмж(компьютер)	14,991.3	16,922.2	1,930.9	7.2
Тавилга, аж ахуйн эд хогшил	6,358.1	6,933.6	575.5	2.9
Зам, гүүрийн байгууламж	4,373.9	4,851.8	477.9	2.1
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	2,026.7	2,026.7	0.0	0.9
Бусад үндсэн хөрөнгө	12,100.7	14,613.6	2,512.9	6.2
Дуусаагүй барилга, байгууламж	3,285.7	3,203.1	-82.6	1.4
Ном	955.6	1,019.2	63.6	0.4
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>827.1</b>	<b>831.9</b>	<b>4.8</b>	<b>0.4</b>
Програм хангамж	139.7	144.2	4.5	0.1
Бусад биет бус хөрөнгө	687.4	687.6	0.23	0.3
<i>Үүнээс байгууллагын төрлөөр харуулбал:</i>				
Төрийн сан	0	0	0	0
Төсөвт байгууллага	181,641.2	199,572.1	17,930.9	84.4
Төсөл сан		0	0.0	
Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж	35,881.7	36,800.4	918.7	15.6
Нийт үндсэн хөрөнгийн дүн	<b>217,522.9</b>	<b>236,372.5</b>	<b>18,849.6</b>	<b>100</b>

Нийт үндсэн хөрөнгийн 84.4 хувийг төсөвт байгууллагуудын, 15.6 хувийг орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө эзэлж байна.

#### 4.2 Үндсэн хөрөнгийн данстай холбоотой гарсан зөрчлийн талаар

Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн түвшинд хийсэн аудитаар үндсэн хөрөнгийн данстай холбоотой нийт 139.0 сая төгрөгийн материаллаг, 2,330.2 сая төгрөгийн материаллаг бус зэрэг нийт 2,469.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнээс аудитын явцад 2,094.3 сая төгрөгийн алдааг залруулж, 3.4 сая төгрөгийн зөрчилд хөрөнгө нөхөн төлүүлэх төлбөрийн акт, 120.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 250.8 сая төгрөгийн зөрчилд аудитын зөвлөмж хүргүүлсэн байна. /Алдаа зөрчлийн дэлгэрэнгүйг хавсралт № 4-т үзүүлэв/

Аудитаар санхүүгийн тайланд хөрөнгийн үлдэгдлийг зөрүүтэй тусгасан, тээврийн хэрэгсэл хувь хүний эзэмшилд бүртгэгдсэн зэрэг материаллаг алдаа зөрчил илэрсэн байна. Үүнд;

- *Бугант тосгоны захирагчийн албаны хөрөнгийн дансанд бүртгэлтэй 36.0 сая төгрөгийн үнэ бүхий тээврийн хэрэгсэл нь хувь хүний эзэмшилд бүртгэлтэй,*
- *“Цант Орхон” ХХК нь ТУЗ-ийн зөвшөөрөлгүйгээр 16.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн, биетээр оршоогүй 1.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үлдэгдлээр тайлагнасан,*
- *Сэлэнгэ-Зүүнхараа” ОНӨААТҮГ санхүүгийн тайлан гаргахын өмнө үндсэн хөрөнгийн тооллого хийсэн боловч бараа материалын тооллого хийгээгүйгээс санхүүгийн тайланд тусгагдсан 84.7 сая төгрөгийн хөрөнгө оршин байгааг нотлох боломжгүй байна,*
- *Үндсэн хөрөнгийн элэгдэлтэй холбоотой 1.1 сая төгрөгийн,*

#### Тав.Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал:

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд өр төлбөрийн эхний үлдэгдэл 9,166.4 сая төгрөг байсан бол тайлант онд 4.9 хувиар буюу 252.8 сая төгрөгөөр буурч, оны эцэст 8,913.6 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

#### 5.1 Өр төлбөрийн бүтэц, бүрэлдэхүүний талаар



Дансны нэр, төрөл	Эцсийн үлдэгдэл /2016.12.31/	Эцсийн үлдэгдэл /2017.12.31/	Өсөлт /+ / бууралт /-/	Дүнд эзлэх хувь
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>9,166.4</b>	<b>8,913.6</b>	<b>-252.8</b>	<b>102.3</b>
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>9,166.4</b>	<b>8,487.3</b>	<b>-679.1</b>	<b>97.4</b>
Богино хугацаат зээлийн өглөг	1,788.2	1,572.5	-215.7	18.0
<b>Өглөг</b>	<b>7,345.1</b>	<b>6,914.8</b>	<b>-430.3</b>	<b>79.4</b>
Ажилчидтай холбогдсон өглөг	18.4	103.9	85.5	1.2
Бараа үйлчилгээний зардлын өглөг	33.7	4.4	-29.3	0.1
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	233.5	0.7	-232.8	0.0
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	220.0	0.0	-220.0	0.0
Байгууллагад төлөх өглөг	729.9	670.4	-59.5	7.7
Хувь хүмүүст төлөх өглөг	5.4	11.3	5.9	0.1
Татварын өр /ОНӨҮГ/	1,379.5	1,513.1	133.6	17.4
НДШ-ийн өр /ОНӨҮГ/	1,166.3	1,505.9	339.6	17.3
Ноогдол ашгийн өр /ОНӨҮГ/	2.0	2.0	0.0	0.0
Дансны өглөг /ОНӨҮГ/	3,556.4	3,103.2	-453.2	35.6
Урьдчилж орсон орлого	<b>33.1</b>	<b>0.0</b>	<b>-33.1</b>	<b>0.0</b>
Бусад урьдчилж орсон орлого	33.1	0.0	-33.1	0.0
<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.0</b>	<b>426.3</b>	<b>426.3</b>	<b>4.9</b>
Арилжааны банк	0.0	411.0	411.0	4.7
Бусад урь хугацаат өр төлбөр /ТӨҮГ/	0.0	15.3	15.3	0.2
<b>Үүнээс байгууллагын төрлөөр харуулбал:</b>				
Төрийн сан	418.0	224.9	-193.1	2.5
Төсөвт байгууллага	535.7	207.7	-328.0	2.3
Төсөл сан	158.8	95.5	-63.3	1.1
Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж	8,053.9	8,385.5	331.6	94.1
<b>Нийт өр төлбөрийн дүн</b>	<b>9,166.4</b>	<b>8,913.6</b>	<b>-252.8</b>	<b>100.0</b>

Нийт өр төлбөрийн 2.3 хувийг төрийн сангийн, 2.5 хувийг төсөвт байгууллагын, 1.1 хувийг төсөл сангийн, 94.1 хувийг орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн өр төлбөр эзэлж байна.

## 5.2 Өр төлбөрийн данстай холбоотой гарсан зөрчлийн талаар

Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн түвшинд хийсэн аудитаар өр төлбөрийн данстай холбоотой 87.1 сая төгрөгийн материаллаг, 17.5 сая төгрөгийн материаллаг бус зэрэг нийт 104.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнээс аудитын явцад 12.8 сая төгрөгийн алдааг залруулж, 91.8 сая төгрөгийн зөрчилд аудитын зөвлөмж хүргүүлсэн байна. /Алдаа зөрчлийн дэлгэрэнгүйг хавсралт № 5-т үзүүлэв/

Аудитаар төсвийг зохистой удирдаагүйгээс өр төлбөр үүсгэсэн, үлдэгдлийг санхүүгийн тайланд дутуу тусгасан, урьд оны санхүүгийн тайланд үлдэгдлээр тусгаагүй өр төлбөрийг тайлант оны зардлаас барагдуулсан зэрэг материаллаг алдаа, зөрчил нийтлэг илэрсэн байна. Үүнд:

- Төсвийг зохистой удирдаагүйгээс шинээр нийт 5.4 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн,
- Урьд оны санхүүгийн тайланд үлдэгдлээр тусгаагаагүй 18.4 сая төгрөгийн өр төлбөрийг тайлант оны зардлаас барагдуулсан,
- Өмнөх онуудаас шилжин ирсэн 50.9 сая төгрөгийн өр төлбөрт дүн шинжилгээ хийж, барагдуулах арга хэмжээ аваагүй,

- Санхүүгийн тайланд нийт 12.4 сая төгрөгийн өр төлбөр дутуу тайлагнасан байна.

## Зургаа. Орлогын бүртгэл, тайлагнал

### 6.1 Төсвийн орлого, санхүүжилтийн талаар

Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 16 дугаар тогтоолоор аймгийн 2017 оны төсвийн нийт орлогыг 63,130.6 сая төгрөгөөр баталсан бөгөөд төсвийн жилийн дундуур 3 удаа тодотгол хийж, 67,481.8 сая төгрөгөөр эцэслэн баталсан байна.

Сумдын дүнг оруулан тооцвол аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаанаар Сэлэнгэ аймгийн 2017 оны төсвийн нийт орлогын төлөвлөгөөг жилийн эцэст 76,028.2 сая төгрөгөөр тодотгож баталсанаас 77,359.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 1.8 хувиар буюу 1,331.5 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

#### Аймаг, сумдын төсвийн нийт орлогын эх үүсвэрийг харуулбал:

/Хүснэгт №7/

( сая төгрөг )

Орлогын эдийн засгийн ангилал	Өмнөх оны гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
<b>Нийт орлого ба тусламж санхүүжилтийн орлого</b>	<b>71,639.4</b>	<b>76,028.2</b>	<b>77,359.5</b>	<b>1,331.3</b>	<b>101.8</b>
<b>Урсгал орлого</b>	<b>18,403.5</b>	<b>21,480.0</b>	<b>23,638.5</b>	<b>2,158.5</b>	<b>110.0</b>
Татварын орлого	16,654.4	19,719.0	21,102.3	1,383.3	107.0
<b>Татварын бус орлого</b>	<b>1,749.1</b>	<b>1,761.0</b>	<b>2,536.2</b>	<b>775.2</b>	<b>144.0</b>
Нийтлэг татварын бус орлого	1,506.3	1,544.5	2,275.4	730.9	147.3
Орон нутгийн төсвийн байгууллагын өөрийн орлого	242.8	211.5	255.8	44.3	120.9
Тусламжийн орлого	-	5.0	5.0	-	100.0
<b>Хөрөнгийн орлого</b>	<b>35.5</b>	<b>23.1</b>	<b>53.5</b>	<b>30.4</b>	<b>231.6</b>
<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	<b>52,118.6</b>	<b>52,633.1</b>	<b>52,633.1</b>	<b>(0.0)</b>	<b>100.0</b>
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	43,171.6	46,644.5	46,644.5	-	100.0
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	4,887.3	2,139.6	2,139.6	-	100.0
Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	4,059.7	3,849.0	3,849.0	(0.0)	100.0
Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын өөрийн орлого	89.1	124.5	117.2	(7.3)	94.1
Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх төлбөрийн орлого	992.7	1,767.5	917.2	(850.3)	51.9

Хүснэгтээс үзэхэд улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлэг, ОНХС-ийн орлогын шилжүүлгийн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, аймаг, сумдын төсвийн нийт орлого 1.8 хувиар давж биелсэн бол төсөвт байгууллагуудын өөрийн орлого 11 хувиар давж биелсэн байна.

#### 6.1.1 Татварын болон татварын бус орлогын талаар

Аймгийн ИТХ-аас аймгийн 2017 оны төсвийн орлогыг анх 1,395.0 сая төгрөгийн ХХОАТ-ын буцаан олголтыг хассан дүнгээр буюу 12,245.1 сая төгрөгөөр баталсан бол төсвийн жилийн дундуур 3 удаа тодотгол хийж, 1,116.0 сая төгрөгийн ХХОАТ-ын буцаан олголтыг хассан дүн болох 12,739.2 сая төгрөгөөр буюу анхны баталсан дүнгээс 494.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, эцэслэн баталсан байна.

Сумдын ИТХ-аас сумдын татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг 8,547.3 сая төгрөгөөр тодотгон баталснаар Сэлэнгэ аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө нийт дүнгээр 21,286.5 сая төгрөгөөр эцэслэн батлагдсан байна.

Гүйцэтгэлээр аймгийн төсөвт 14,022.0 сая төгрөгийн, сумдын төсөвт 9,409.2 сая төгрөгийн зэрэг нийт 23,431.2 сая төгрөгийн орлого төвлөрч, батлагдсан төлөвлөгөөг 10,0 хувиар давуулан биелүүлсэн байна.

### Аймгийн төсвийн татварын болон татварын бус орлогын

#### гүйцэтгэлийг харуулбал:

/Хүснэгт №8/

( сая төгрөг)

Орлогын нэр төрөл	Өмнөх он	2017 оны төлөвлөгөө, гүйцэтгэл							
		Аймгийн орлого		Сумдын орлого		Төсвийн нийт орлого			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Татварын болон татварын бус орлогын нийт дүн</b>	<b>18,196.2</b>	<b>12,739.2</b>	<b>14,022.0</b>	<b>8,547.3</b>	<b>9,409.2</b>	<b>21,286.5</b>	<b>23,431.2</b>	<b>2,144.7</b>	<b>110</b>
<b>Татварын орлого</b>	<b>16,654.0</b>	<b>12,336.8</b>	<b>13,165.5</b>	<b>7,382.3</b>	<b>7,936.8</b>	<b>19,719.0</b>	<b>21,102.3</b>	<b>1,383.3</b>	<b>107</b>
Хүн амын орлогын албан татвар	10,561.9	9,663.0	10,407.5	970.7	1,280.0	10,633.6	11,687.5	1,053.9	110
Өмчийн татвар	943.1	1,420.0	1,566.4	0.0	0.0	1,420.0	1,566.4	146.4	110
Бараа үйлчилгээний албан татвар	5,149.0	1,253.8	1,191.6	6,411.6	6,656.8	7,665.4	7,848.4	183.0	102
<b>Татварын бус орлого</b>	<b>1,503.6</b>	<b>379.3</b>	<b>803.0</b>	<b>1,165.1</b>	<b>1,472.4</b>	<b>1,544.4</b>	<b>2,275.4</b>	<b>731.0</b>	<b>147</b>
Торгууль, шимтгэл	892.4	150.0	494.8	682.0	1,019.0	832.0	1,513.8	681.8	182
Татварын бус бусад орлого	611.2	229.3	308.2	483.1	453.4	712.4	761.6	49.2	107
Өмчийн орлого	38.6	23.1	53.5	0.0	0.0	23.1	53.5	30.4	232

Гүйцэтгэлээс үзэхэд нийт дүнгээр хүн амын орлогын албан татвар 1,053.9 сая төгрөгөөр, өмчийн татвар 146.4 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний албан татвар 183.0 сая төгрөгөөр татварын бус орлого 731.0 сая төгрөгөөр, өмчийн орлого 30.4 сая төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

Аймгийн орлого нийт дүнгээрээ 10.3 хувиар давж биелэсэн боловч нэр төрлөөр нь авч үзэхэд ус ашигласны төлбөрийн орлого 93.7 сая төгрөгөөр буюу 12.8 хувиар тасарсан байна.

Аймаг, сумдын төсвийн 2017 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг харуулбал:

/Хүснэгт №9 /

( сая төгрөг)

д/д	Сумдын нэр	Өмнөх оны гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Алтанбулаг	409.2	449.8	437.9	(11.9)	97.3
2	Баруунбүрэн	100.2	84.1	125.2	41.0	148.7
3	Баянгол	120.0	326.6	356.3	29.7	109.1
4	Ерөө	725.2	931.7	1,096.5	164.8	117.7
5	Хүдэр	1,259.4	2,636.0	2,740.9	104.9	104.0
6	Хушаат	29.4	62.8	74.2	11.4	118.1
7	Жавхлант	35.5	69.2	113.0	43.9	163.4

8	Мандал	1,386.7	2,419.3	2,646.7	227.4	109.4
9	Орхон	48.4	72.6	74.3	1.7	102.4
10	Орхонтуул	73.2	77.9	109.8	31.9	141.0
11	Сайхан	365.4	364.8	447.6	82.8	122.7
12	Сант	50.2	81.0	88.0	7.0	108.6
13	Шаамар	95.5	121.3	123.5	2.2	101.8
14	Сүхбаатар	348.9	590.1	694.8	104.7	117.7
15	Цагааннуур	84.3	106.2	118.3	12.1	111.4
16	Түшиг	149.2	91.9	95.3	3.4	103.6
17	Зүүнбүрэн	32.0	62.0	67.1	5.1	108.2
	<b>Сумдын дүн</b>	<b>5,312.7</b>	<b>8,547.3</b>	<b>9,409.2</b>	<b>861.9</b>	<b>110.1</b>
18	Аймгийн орлого	12,883.5	12,739.2	14,022	1,282.8	110.1
	<b>Нийт дүн</b>	<b>18,196.20</b>	<b>21,286.5</b>	<b>23,431.2</b>	<b>2,144.7</b>	<b>110.1</b>

Төсвийн орлогын төлөвлөгөөг Алтанбулаг сум 11.9 сая төгрөгөөр тасалсан бол бусад 16 сумдын төлөвлөгөө 1.8-63.4 хувиар давж биелсэн байна.

Сумдын орлогын гүйцэтгэл нийт дүнгээр биелсэн боловч нэр төрлөөр нь авч үзэхэд орлогын албан татвар 311.0 сая төгрөгөөр, хүн амын ундны ус ашигласны төлбөрийн орлого 16.5 сая төгрөгөөр, ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 241.9 сая төгрөгөөр, байгалийн ургамал ашигласны төлбөр 124.9 сая төгрөгөөр, хүү торгуулийн орлого 336.9 сая төгрөгөөр давж биелэн, хөрөнгийн хөдлөл эрхийн орлого 1.6 сая төгрөгөөр, бууны албан татвар 1.0 сая төгрөгөөр, агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлого 12.0 сая төгрөгөөр, хог хаягдлын хураамжийн орлого 97.4 сая төгрөгөөр, бусад орлого 29.7 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

### 6.1.2 Төсөвт байгууллагуудын өөрийн орлогын талаар

Орон нутгийн төсөвт байгууллагуудын өөрийн орлогын төлөвлөгөө 211.5 сая төгрөгөөр батлагдаж , 255.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын өөрийн орлогын төлөвлөгөө 124.5 сая төгрөгөөр батлагдаж , 117.2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

### 6.2 Орлогын данстай холбоотой гарсан зөрчлийн талаар

Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн түвшинд хийсэн аудитаар орлогын данстай холбоотой нийт 97.1 сая төгрөгийн материаллаг, 535.9 сая төгрөгийн материаллаг бус зэрэг нийт 633.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнээс аудитын явцад 172.2 сая төгрөгийн алдааг залруулж, 8.8 сая төгрөгийн зөрчилд хөрөнгө нөхөн төлүүлэх төлбөрийн акт, 72.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 379.7 сая төгрөгийн зөрчилд аудитын зөвлөмж хүргүүлсэн байна./ Алдаа зөрчлийн дэлгэрэнгүйг хавсралт № 6-д үзүүлэв/

А) Аудитаар төсвийн орлогын төлөвлөгөөг тасалсан, улс, аймгийн төсвийн орлогыг сумын төсөвт төвлөрүүлсэн, байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөг тасалсан болон касст бэлнээр авч зарцуулсан зэрэг материаллаг алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн 8 байгууллага өөрийн орлогын төлөвлөгөөг нийт 17.3 сая төгрөгөөр тасалсан,
- Алтанбулаг сум орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 11.9 сая төгрөгөөр тасалсан,
- Баянгол сум улсын төсөвт төвлөрүүлэх 6.4 сая төгрөгийн орлогыг ЗДТГ-ын дансаар дамжуулан зарцуулсан,

- *Ерөө, Баянгол, Шаамар, Орхонтуул зэрэг сумдууд аймгийн төсөвт төвлөрүүлэгдэх 17.8 сая төгрөгийг сумын төсөвт төвлөрүүлэн зарцуулсан,*
- *Мандал сумын 4-р сургууль 1.4 сая төгрөгийн өөрийн орлогыг төрийн сангийн бүртгэлийн дансанд төвлөрүүлэхгүйгээр бэлнээр авч захиран зарцуулсан,*
- *Түшиг сумын ЭМТ 3.5 сая төгрөгийн, Хүдэр сумын ЭМТ 5.4 сая төгрөгийн эмийн сангийн орлогыг төрийн сангийн бүртгэлийн дансанд төвлөрүүлээгүй,*
- *“Мандал хишиг хайрхан” ОНӨААТҮГ нийт 45.6 сая төгрөгийн борлуулалтын орлого төвлөрүүлсний 70.4 хувийг буюу 32.1 сая төгрөгийг кассат бэлнээр авсан боловч кассын орлогын ордерыг дугаарлаагүй, бүртгэлээр хяналт тавих нөхцөлийг бүрдүүлээгүй зарцуулсан,*

Б) Дуудлага худалдаагаар борлуулсан хөрөнгийн 1,4 сая төгрөгийн, хөрөнгө түрээслүүлсэн 0.3 сая төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн байна. Үүнд:

- *Мандал сумын Цагдаагийн хэлтэст бүртгэлтэй байсан /Хонда HR-V/ авто машиныг 2016 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр 81 дугаар бүхий гэрээ байгуулан борлуулсан ч 0.2 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлээгүй,*
- *Гавшгай-Ус ХХК-д бүртгэлтэй байсан /УАЗ-469/ авто машиныг 2017 оны 02 дугаар сарын 06-ны өдөр гэрээ байгуулан 0.7 сая төгрөгөөр борлуулсан ч орлогыг төвлөрүүлээгүй,*
- *Баянгол сумын ЗДТГ-т бүртгэлтэй байсан /Ланд крузер 80/ авто машиныг 2017 оны 08 дугаар сард 1,200.0 мянган төгрөгөөр борлуулсан ч 0.5 сая төгрөгийн орлого дутуу төвлөрүүлсэн байна.*
- *Орон нутгийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлсний 0,3 сая төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн байна.*

В) Аймгийн ИТХ-ын 2017 оны 21 дүгээр тогтоолоор Хөтөлийн “Цемент шохой” ХК-ийн ХХОАТ-ын авлагаас Замын сангийн хөрөнгө оруулалтад 428.6 сая төгрөг зарцуулахаар баталсан байна. Тогтоолыг үндэслэн аймгийн Татварын хэлтэс, “Цемент шохой” ХХК-ийн хооронд 2017 оны 04-р сарын 25-ны өдөр ХАГ/2017/54 дугаар бүхий хамтран ажиллах гэрээ байгуулан, 8 аж ахуйн нэгж, байгууллагад нийт 3489.11 тн буюу 534.8 сая төгрөгийн цемент нийлүүлэгдсэн байна. Үүнээс аж ахуйн нэгж байгууллагууд аймгийн хүү, торгуулийн орлогын дансанд 190.5 сая төгрөг, ХХОАТ-ын дансанд 126.8 сая төгрөг зэрэг нийт 317.3 сая төгрөгийг төвлөрүүлж, 127.6 сая төгрөгийг замын сан, ОНХО-ын санхүүжилтэд суутган тооцсон байна. Уг орлого нь ХХОАТ –ын бүрдүүлэлт боловч 318.2 сая төгрөгийг хүү торгуулийн орлогоор тайлагнасан байна. Аймгийн ИТХ-аас Замын сангийн хөрөнгө оруулалтын ажлыг гүйцэтгэж буй компаниудад Цемент шохой компанийн ХХОАТ-ын авлагаас тооцон цемент олгохоор шийдвэрлэсний дагуу замын сангийн эх үүсвэрээр ажил гүйцэтгэж буй Сэлэнгэ 9 эрдэнэ, Сэлэнгэ АЗЗА зэрэг 2 компанид 202,6 сая төгрөгийн, орон нутгийн хөрөнгө оруулалтаар ажил гүйцэтгэж буй Хилийн цэргийн 101 дүгээр ангид 9,6 сая төгрөгийн, Хөтөл Төвхөн компанид 25,0 сая төгрөгийн зэрэг нийт 237,2 сая төгрөгийн цемент олгосон бол хөрөнгө оруулалтын ажил гүйцэтгээгүй 4 компанид нийт 297,6 сая төгрөгийн цемент олгосон боловч төлбөр тооцоог бүрэн хийж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна. Иймээс эдгээр компаниудтай үүссэн төлбөр тооцоо, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах нь зүйтэй юм.

## **Долоо. Зардлын бүртгэл, тайлагнал:**

### **7.1 Аймгийн төсвийн нийт зарлагын талаар**

Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 16 дугаар тогтоолоор аймгийн 2017 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын хэмжээг 63,130.6 сая төгрөгөөр баталсан байна. Анх баталсан төсвийн

зарлагыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 21 дүгээр тогтоолоор 64,132.3 сая төгрөгөөр, 2017 оны 33 дугаар тогтоолоор 67,501.1 сая төгрөгөөр, 35 дугаар тогтоолоор 67,481.8 сая төгрөгөөр тус тус өөрчилж, 3 удаа тодотгол хийсэн байна.

Сумдын дүнг нэгтгэн авч үзвэл аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар Сэлэнгэ аймгийн 2017 оны төсвийн нийт зарлагын төлөвлөгөөг эцсийн байдлаар 78,874.5 сая төгрөгөөр тодотгож баталсан бол гүйцэтгэлээр нийт 76,839.4 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төлөвлөгөөг 2,035.0 сая төгрөгөөр хэмнэн, 97.4 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Төсвийн зардлын гүйцэтгэлийг графикаар харуулбал:

График 1



Нийт төсвийн зардлын 38.6 хувийг орон нутгийн төсвийн байгууллагын, 60.8 хувийг тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын, 0.6 хувийг төсөл сангийн зардал эзэлж байна.

### 7.1.1 Орон нутгийн төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийн талаар:

Орон нутгийн төсвийн 2017 оны нийт зарлага 32,105.5 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 30,106.6 сая төгрөг буюу 93.8 хувийн биелэлттэй тайлагнагдсан байна.

Орон нутгийн төсвийн нийт зарлагыг эдийн засгийн ангилалаар харуулбал:

/Хүснэгт №10/

(сая төгрөг)

ҮЗҮҮЛЭЛТ	2016 оны гүйцэтгэл	2017 оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>27,510.0</b>	<b>32,105.5</b>	<b>30,106.6</b>	<b>1,998.9</b>	<b>93.8</b>
<b>А.Урсгал зардал</b>	<b>20,474.0</b>	<b>22,729.5</b>	<b>22,314.8</b>	<b>414.7</b>	<b>74.1</b>
Бараа үйлчилгээний зардал	12032.3	13,452.8	13,060.0	392.9	43.4
Татаас	251.2	430.6	428.8	1.9	1.4
Урсгал шилжүүлэг	8190.6	8,846.0	8,826.1	19.9	29.3
<b>Б. Хөрөнгийн зардал</b>	<b>6159.3</b>	<b>7,670.8</b>	<b>7,331.9</b>	<b>338.9</b>	<b>24.4</b>
В. Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	<b>876.6</b>	<b>1,705.2</b>	<b>459.9</b>	<b>1,245.3</b>	<b>1.5</b>

Өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад нийт зарлага 9.4 хувиар буюу 2,596.6 сая төгрөгөөр өссөн байна.

Орон нутгийн байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансанд оны эхний үлдэгдлээс 240.5 сая төгрөгийн, бусад эх үүсвэрээс 2,392.5 сая төгрөгийн зэрэг нийт 2,633.0 сая төгрөгийн орлого төвлөрснөөс 2,371.5 сая төгрөгийг үйл ажиллагаанд

зарцуулан, 261.5 сая төгрөгийг төвлөрүүлж, оны эцэст үлдэгдэлгүйгээр тайлагнагдсан байна.

### 7.1.2 Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн зардлын гүйцэтгэлийн талаар:

2017 онд тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын нийт зарлага 46,769.0 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 46,732.8 сая төгрөг буюу 99.9 хувийн биелэлттэй тайлагнагдсан нь өмнөх оноос 3,894.8 сая төгрөгөөр буюу 9.1 хувиар өссөн байна.

#### Төсвийн гүйцэтгэлийг хөтөлбөрийн ангилалаар харуулбал:

/Хүснэгт №11/

(сая төгрөг)

ҮЗҮҮЛЭЛТ	2016 оны гүйцэтгэл	2017 оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>42,838.0</b>	<b>46,769.0</b>	<b>46,732.8</b>	<b>36.2</b>	<b>99.9</b>
<b>А.Урсгал зардал</b>	<b>42,838.0</b>	<b>46,769.0</b>	<b>46,732.8</b>	<b>36.2</b>	<b>99.9</b>
Бараа үйлчилгээний зардал	40070.8	41,893.5	41,862.6	30.9	89.6
Татаас	321.1	395.0	395.0	-	0.8
Урсгал шилжүүлэг	2446.1	4,480.5	4,475.2	5.3	9.6
Б. Хөрөнгийн зардал		-	-	-	-
В. Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл		-	-	-	-
Үүнээс: Сайдын төсвийн багцаар харуулбал:					
БСШУСС	36,866.4	40,619.6	40,604.2	15.38	100.0
ЭМС	5,479.7	5,613.6	5,608.9	4.70	99.9
ХНХС	263.4	305.6	289.4	16.14	94.7
БХБС	228.5	230.2	230.2	-	100.0
<b>Нийт дүн</b>	<b>42,838.0</b>	<b>46,769.0</b>	<b>46,732.8</b>	<b>36.21</b>	<b>99.9</b>

Төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийн 86,0 хувийг БСШУСС-ын, 12,0 хувийг ЭМС-ын, 0.5 хувийг БХБС-ын, 0.6 хувийг ХНХС-ын багцын байгууллагуудын зардал эзэлж байна.

Нийт төсвийн зардлын 89.6 хувийг бараа үйлчилгээний зардалд, 0.8 хувийг татаас санхүүжилтийн зардалд, 9.6 хувийг урсгал шилжүүлгийн зардалд зарцуулсан байна.

ТЗШ-ийн байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд урьд оны үлдэгдлээс 17.9 сая төгрөгийн, бусад эх үүсвэрээс 1,264.7 сая төгрөгийн зэрэг нийт 1,282.6 сая төгрөгийн орлого төвлөрснөөс 1,250.6 сая төгрөгийг зарцуулан, 32.0 сая төгрөгийг буцаан төвлөрүүлж, оны эцэст 200 төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

### 7.2 Зардлын данстай холбоотой гарсан зөрчлийн талаар:

Төсвийн шууд, төвлөрүүлэн болон ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зардлын дансны бүртгэл, тайлагнал, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой 2,977.7 сая төгрөгийн материаллаг, 3,030.2 сая төгрөгийн материаллаг бус зэрэг нийт 5,647.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнээс аудитын явцад 2,334.6 сая төгрөгийн алдааг залруулж, 32.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 807.9 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага, 2,472.9 сая төгрөгийн зөрчилд аудитын зөвлөмж өгсөн байна./ Алдаа зөрчлийн дэлгэрэнгүйг хавсралт №7-10 -т үзүүлэв./



## 7.2.1 Цалингийн зардлын гүйцэтгэлтэй холбоотой илэрсэн алдаа, зөрчлийн талаар

ТЕЗ-ийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар цалингийн зардлын гүйцэтгэлтэй холбоотой 115.6 сая төгрөгийн материаллаг, 26.6 сая төгрөгийн материаллаг бус зэрэг нийт 142.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна. Үүнээс аудитын явцад 14.7 сая төгрөгийн алдааг залруулж, 27.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 34.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 65.8 сая төгрөгийн зөрчилд аудитын зөвлөмж өгөгдсөн байна. *Алдаа, зөрчлийн дэлгэрэнгүйг хавсралт № 7-д үзүүлэв./*

Аудитаар холбогдох хууль, журмыг мөрдөөгүйгээс үндсэн болон цалингийн нэмэгдлийг илүү тооцож олгосон, үндэслэлгүйгээр илүү цалин олгосон, урамшуулал давхардуулан олгосон, батлагдсан орон тоог хэтрүүлсэн зэрэг материаллаг алдаа, зөрчил нийтлэг илэрсэн байна. Үүнд:

- *Батлагдсан орон тоог хэтрүүлэн 16.9 сая төгрөгийн цалин, НДШ-ийн зардал гаргасан,*
- *Тушаал шийдвэргүй болон хууль эрх зүйн үндэслэлгүйгээр нийт 24.4 сая төгрөгийн цалин илүү олгосон,*
- *Үр дүнгийн урамшуулалт цалинг илүү болон давхардуулан олгоход нийт 33.4 сая төгрөг зарцуулсан,*
- *Ээлжийн амралтаа эдэлж буй албан хаагчдад 12.0 сая төгрөгийн цалин бодож олгосон, ээлжийн амралтыг биеэр эдлүүлэлгүйгээс 12.0 сая төгрөгийн цалин давхардуулан олгосон,*
- *Журмын дагуу ажилтнуудын ажлыг үнэлж , дүгнэлгүйгээр ур чадварын нэмэгдлийг хавтгайруулж болон илүү тооцож, нийт 11.3 сая төгрөг олгосон,*
- *Тооцооллыг буруу хийснээс нийт 3.2 сая төгрөгийн цалин илүү олгосон,*
- *УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолыг зөрчин цалингийн шатлал, зэрэглэл нэмэгдүүлж, 1.3 сая төгрөгөөр цалингийн зардлыг нэмэгдүүлсэн,*
- *Цалингийн зардлыг 1,1 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.*

## 7.2.2 Бусад зардлын гүйцэтгэл болон бүртгэл тайлагналтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар

**7.2.2.1** ТЕЗ-ийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар бусад зардлын гүйцэтгэлтэй холбоотой 1,156.1 сая төгрөгийн материаллаг, 904.0 сая төгрөгийн материаллаг бус зэрэг нийт 1,824.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 682.3 сая төгрөгийн алдааг залруулж, 4.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, 94.3 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага, 1,043.6 сая төгрөгийн зөрчилд аудитын зөвлөмж хүргүүлэв./ *Алдаа, зөрчлийн дэлгэрэнгүйг хавсралт № 8-д үзүүлэв./*

А) Холбогдох байгууллагын зөвшөөрөлгүйгээр зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээг гүйцэтгэсэн , сахилгын шийтгэлтэй албан хаагчдад төрөөс олгох урамшуулал олгосон, төсвийг зориулалт бусаар зарцуулсан, орон тоо хэтрүүлэн ажилласан зэрэг 197.5 сая төгрөгийн материаллаг алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнд:

- *Зардлын бүлэг хооронд холбогдох байгууллагын зөвшөөрөлгүйгээр нийт 62.2 сая төгрөгийг гүйлгэн зарцуулсан,*
- *Сахилгын шийтгэлтэй албан хаагчдад төрөөс олгох 42.4 сая төгрөгийн урамшууллыг олгосон,*



- Орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн 16 байгууллага 54.1 сая төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил, гүйлгээг зардалд бүртгэсэн,
- Шаамар сумын ИТХ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 08 дугаар захирамжийн дагуу ИТХ-ын хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас **8.0 сая төгрөгийг** /Дэлхийн Монгол Аялал ХХК руу шилжүүлсэн/ ИТХ-ын тэргүүлэгч, төлөөлөгчид, төр, төсвийн байгууллагуудын удирдлагууд нийлсэн нийт 36 хүний бүрэлдэхүүнтэйгээр БНХАУ-ын Манжуур хотод хөдөө аж ахуйн хүлэмжийн аж ахуйтай танилцах, туршлага судлах ажлаар явахад зарцуулсан байна,
- Аймгийн Цагдаагийн газрын 2017.08.02-ны өдрийн 50/1-2593 дугаар албан бичгээр Шаамар сумын Засаг даргад тавьсан хүсэлтийн дагуу мэдүүлэг авах тусгайлан бэлдсэн өрөөг засварлахад шаардлагатай **10.0 сая төгрөгийн зардлыг** сумын ИТХ-ын төсөвт тодотгол хийж, санхүүжүүлсэн,
- Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь мэдээлэл технологи, үйлчилгээний зардалд батлагдсан төсвөөс хяналт шалгалт, аудитын болон вирусын програмын төлбөрт 4.6 сая төгрөг шилжүүлж, програм бус хөрөнгө худалдан авах, сургалт зохион байгуулах зэргээр зориулалт бусаар зарцуулсан бөгөөд хөрөнгүүд нь бэлтгэн нийлүүлэгч байгууллагын зарлагын падаан болон үйлдвэрлэгдсэн хугацаа, хүчин чадлыг илэрхийлсэн бүтээгдэхүүний паспортаар, сургалтын зардал нь сургалт болсон тухай гүйцэтгэлийн тайлан зэрэг анхан шатны баримтаар бүрэн нотлогдохгүй байна,
- Баянгол сум ИТХ-ын нарийн бичгийн дарга А.Бадамдоржийн Удирдлагын акадамын “Төрийн захиргааны менежмент”-ийн бакалаврын сургалтад хувиараа сурч буй сургалтын төлбөрт 2.5 сая төгрөг баталж, санхүүжүүлсэн,
- Цагааннуур Сумын ЗДТГ- нь Санхүүгийн албанд 1 орон тоо хэтрүүлэн ажиллаж цалин, НДШ-д 8.1 сая төгрөгийн зардал гаргасан,
- Холбогдох хууль тогтоомж зөрчсөн бусад 5.6 сая төгрөгийн зардал гарсан байна.

Б) Аймаг, сумдын Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтай холбоотой нөөц хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, гүйцэтгэлийн болон анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил, гүйлгээг гүйцэтгэж, бүртгэлд тусгасан, Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэргүйгээр хөрөнгө захиран зарцуулсан зэрэг 237.6 сая төгрөгийн материаллаг алдаа зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Аймгийн ЗДН хөрөнгөөс 9 удаагийн 8.0 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан,
- Аймгийн ЗДН хөрөнгөөс зарцуулсан 34.5 сая төгрөгийн 7 арга хэмжээний төсвийн зардлын гүйцэтгэлийн тайланг гаргаагүй, 94.1 сая төгрөгийн арга хэмжээний тайлан, анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил, гүйлгээг гүйцэтгэж, бүртгэлд тусгасан,
- Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэргүйгээр 3 арга хэмжээнд 4.7 сая төгрөгийг зарцуулсан,
- Аймгийн ЗДН хөрөнгөөс кассаар зарцуулсан 60.0 сая төгрөгийн ажил гүйлгээний бэлэн мөнгөний кассын тайланг зохих заавар, журмын дагуу гаргаагүй, бэлэн мөнгийг дарга, нягтлан бодогчийн цохолтгүйгээр зарцуулсан, бэлэн мөнгө хүссэн өргөдөл, бэлэн мөнгөний зарлагын баримтыг үйлдээгүй, мөнгөн урьдчилгааны тайланг гаргаагүй байна.
- Түшиг сум ЗДН хөрөнгөөс 0.8 сая төгрөгийг шинэ жилийн арга хэмжээнд зарцуулсан,
- Хүдэр сумын ЗДН хөрөнгөөс 10 удаагийн 37.6 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын арга хэмжээнд буюу зориулалт бусаар зарцуулсан,

В) Засгийн газрын нөөц сангаас төрийн үйлчилгээнд ашиглагдаж буй техник хэрэгсэл, автомашины хэвийн ажиллагаа, бэлэн байдлыг хангах зориулалтаар 220.0 сая төгрөгийн санхүүжилт хуваарилсныг орон нутгийн төсвийн 5 /аймгийн болон Сайхан, Хүдэр, Зүүнбүрэн сумдын ЗДТГ, Номын сан/, улсын төсвийн 3 /Шаамар сумын МСҮТөө, ГИХГ-ын Хойд бүс дэх газар, аймгийн Нэгдсэн эмнэлэг/ байгууллагад автомашин худалдан авах, аймгийн Нэгдсэн эмнэлэгт бүрэн тоноглогдсон 200 ширхэг ор худалдан авахад тус тус зарцуулсан байна.

Эдгээр хөрөнгийн худалдан авах ажиллагааны гүйцэтгэчийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар сонгон шалгаруулалгүйгээр шууд гэрээ байгуулах аргаар гүйцэтгэсэн бөгөөд аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид хуваарилсан хөрөнгөөс улсын төсвийн байгууллагуудад авто машин, тоног төхөөрөмж худалдан авахад 133,5 сая төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6-д “Тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх.”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т “Хуульд энэ хуулийн 7.1.2-7.1.4-т заасан журмыг хэрэглэхээр зааснаас бусад тохиолдолд нээлттэй тендер шалгаруулалтын журмыг мөрдөнө.”, 8.7.1-д “тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгох”, ЗГ-ын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнийг зөрчсөн байна.

Г) Хушаат сумын сургууль нь жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн цаглабарт хугацаанд аудитад хамруулаагүй бөгөөд санхүү, нягтлан бодох бүртгэлийн сүүлийн хагас жилийн баримт материалыг ирүүлээгүй, албан тушаалтнуудын зүгээс хяналт тавьдаггүйгээс хүнсний тайланг тухай бүр гаргаагүй, материалын үлдэгдлийг хасах утгаар тайлагнасан зэрэг нь тус байгууллагын санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлээгүй гэж үзэхэд хүргэн **санал дүгнэлт өгөхөөс татгалзлаа.**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд тус сургуулийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 501.0 сая төгрөгөөр алдаа, зөрчил тооцсон болно.

**7.2.2.2 Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн** зардлын гүйцэтгэлтэй холбоотой 894.5 сая төгрөгийн материаллаг, 1,124.5 сая төгрөгийн материаллаг бус зэрэг нийт 2,019.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнээс аудитын явцад 999.3 сая төгрөгийн алдааг залруулж, 321.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 698.3 сая төгрөгийн зөрчилд аудитын зөвлөмж өгсөн байна. /Алдаа, зөрчлийн дэлгэрэнгүйг хавсралт № 8-д үзүүлэв./

А) Аудитаар анхан шатны баримтгүй ажил, гүйлгээг гүйцэтгэж, бүртгэлд тусгасан, хөрөнгө, материалын худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, хандив тусламж олгосон, нягтлан бодох бүртгэлийг стандартын дагуу хөтөлж, санхүүгийн тайлан гаргаагүй зэрэг нийт 894.5 сая төгрөгийн материаллаг алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Орон нутгийн өмчит 7 аж ахуйн нэгж байгууллага 63.1 сая төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил, гүйлгээг гүйцэтгэж, зардалд бүртгэсэн,
- “Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ 208.6 сая төгрөгийн, “Сэлэнгэ үйлчилгээ” ОНӨААТҮГ 47.6 сая төгрөгийн, “Урсгал ус” ХХК 22.9 сая төгрөгийн зэрэг нийт 279.0 сая төгрөгийн шууд худалдан авах босго үнээс давсан хөрөнгө, материалын худалдан авалтын гүйцэтгэгчийг шууд гэрээ байгуулах аргаар сонгон шалгаруулсан,
- “Гавшгай ус” ХХК ТУЗ-өөс баталсан зардлын хэмжээг 317.6 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан,
- “Урсгал ус” ХХК 1.0 сая төгрөгийн, Гавшгай ус” ХХК 0.3 сая төгрөгийн зэрэг нийт 1.3 сая төгрөгийн хандив тусламжийн зардал гаргасан,

- “Сэлэнгэ үржлийн цөм сүрэг” ОНӨААТҮГ нягтлан бодох бүртгэлийг холбогдох хууль, стандартын дагуу хөтлөлөгүүгээр 7.3 сая төгрөгийн зардлын гүйлгээ хийсэн,
- “Сэлэнгэ зүүнхараа” ОНӨААТҮГ хөрөнгө оруулалтын зардлыг 3.6 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Б) Тайлант оны эцэст “Урсгал ус” ХХК, “Туулын хишиг”, “Сэлэнгэ-Энерго”, “Сэлэнгэ үйлчилгээ”, “Сэлэнгэ үржлийн цөм сүрэг”, “Сэлэнгэ зүүнхараа” “Хүдэр ойн анги”, “Мандал хишиг хайрхан”, “Хүдэр тохижилт” “Сэлэнгэ баялаг ирээдүй” зэрэг 9 аж ахуйн нэгж нийт 222.3 сая төгрөгийн алдагдалтай тайлагнагдсан байгаа нь / Сэлэнгэ-Энерго ороогүй / Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж.....” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд үйл ажиллагааны үр дүнгээр ашигтай ажиллаж, өөрөө өөрийгөө санхүүжүүлж чадахгүй байна.

### **7.2.3 НДШ, ХХОАТ, НӨАТ-ын бүртгэл тайлагналтай холбоотой гарсан алдаа зөрчлийн талаар**

А) ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар ХХОАТ, НДШ-ийг илүү, дутуу тайлагнасан, татвар, шимтгэлийг төсөвт дутуу төвлөрүүлсэн зэрэг нийт 77.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, аудитын явцад 46.3 сая төгрөгийн алдааг залруулж, 0.6 сая төгрөгийн төлбөрийн акт, 30.3 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлсэн байна. /дэлгэрэнгүйг хавсралт №9-д үзүүлэв/

### **7.2.4 Замын сан, хөрөнгө оруулалтын барьцааны дансны талаар**

Аймгийн ИТХ-ын 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 33 дугаар “Сэлэнгэ аймгийн 2017 оны тодотгосон төсөв батлах тухай” тогтоолоор урьд оноос шилжих 6 төсөл, арга хэмжээнд 221.1 сая төгрөгийн, шинээр эхлэх 21 төсөл, арга хэмжээнд 720.5 сая төгрөгийн зэрэг нийт 941.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зардлыг баталсан байна.

Гүйцэтгэлээр өмнөх оноос шилжиж ирсэн 6 төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 467.6 сая төгрөгийг, шинээр эхлүүлсэн 20 төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 693.4 сая төгрөгийг зарцуулж, төсвийн гүйцэтгэл цэвэр дүнгээр 911.7 сая төгрөгөөр буюу 96.8 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

А) **Замын сангийн хөрөнгийн зарцуулалттай** холбоотой 84.2 сая төгрөгийн материаллаг алдаа зөрчил илэрлээ: Үүнд:

Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэгдсэн нэр төрөл, газар зүйн байрлалын хувьд нэг төрлийн “Сүхбаатар сумын дотор хайрган хучилттай зам, талбайг асфальт бетоноор хучих” 44.9 сая төгрөгийн, “Сүхбаатар сумын 15,16-р байрны авто зогсоол байгуулах” 39.3 сая төгрөгийн ажлуудыг нэг багц болгож нээлттэй сонгон шалгаруулалт зохион байгуулаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-д “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртөгийг үндэслэл болгоно”, 8.5-д “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно”, 8.7.1-д “тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгох” гэж заасныг зөрчсөн байна.

## 7.2.5 Орон нутгийн хөрөнгө оруулалт, түүний гүйцэтгэлтэй холбогдон гарсан зөрчлийн талаар

Аймгийн ИТХ-ын 2017 оны 11 дугаар сарын 14-ний өдрийн 33 дугаар “Сэлэнгэ аймгийн 2016 оны тодотгосон төсөв батлах тухай” тогтоолоор урьд оноос шилжих 16 төсөл, арга хэмжээнд 307.7 сая төгрөгийн, шинээр эхлэх 54 төсөл, арга хэмжээнд 1,379.7 сая төгрөгийн нийт 1,687.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зардлыг эцэслэн баталсан байна.

Гүйцэтгэлээр өмнөх оноос шилжиж ирсэн 15 төсөл арга хэмжээний санхүүжилтэд 282.1 сая төгрөгийг, шинээр эхлүүлсэн 52 төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 1,366.1 сая төгрөгийг зарцуулж, аймгийн төрийн санд байрших орон нутгийн хөрөнгө оруулалтын барьцааны дансанд 35.6 сая төгрөгийг шилжүүлэн, төсвийн гүйцэтгэл цэвэр дүнгээр 1,648.2 сая төгрөгөөр буюу 97.7 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

Аудитаар аймаг, сумдын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой 205.5 сая төгрөгийн дараах зөрчил илэрлээ. /Алдаа зөрчлийн дэлгэрэнгүйг хавсралт № 10-д үзүүлэв /

А) Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнд улсын төсвийн байгууллагуудын урсгал зардал болон хөрөнгө худалдан авахад 84.3 сая төгрөгийг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Алтанбулаг дахь Гаалийн шалган нэвтрүүлэх байрны нийтийн бие засах өрөөний тохижилтод 40.0 сая төгрөг,
- Аймгийн Татварын хэлтэст тоног төхөөрөмж худалдан авахад 25.0 сая төгрөг,
- Хилийн цэргийн 0101 дүгээр ангийн засварт 9.5 сая төгрөг,
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны уулзалтын өрөөг тохижуулахад 5.0 сая төгрөг,
- Аймгийн Прокурорын газарт архивын шүүгээ худалдан авахад 4.8 сая төгрөг,

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.6.6 дахь “Тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аймгийн Татварын хэлтэст тоног төхөөрөмж худалдан авах 25.0 сая төгрөгийн, Хилийн цэргийн 0101 дүгээр ангийн засварын 9.5 сая төгрөгийн зэрэг нийт 34.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг “Хөтөл Цемент шохой” ХК-ийн татварын өрөнд суутгасан цементийн тооцоогоор хааж, бусад төсөл арга хэмжээний санхүүжилтэд 78,1 сая төгрөг олгосон байна.

Б) Хүдэр сум орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлаас сумын ИТХ-ын тогтоолоор батлагдаагүй төсөл арга хэмжээ буюу 20.0 сая төгрөгийн үнэтэй Зил-130 автомашиныг худалдан авсан боловч худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, ОНХО-аар хийгдсэн 3 төсөл арга хэмжээг комиссын актаар хүлээн аваагүй байхад үлдэгдэл 6.2 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид шилжүүлсэн,

В) Мандал сум орон нутгийн төсвийн хөрөнгөөр Онцгой байдлын хэлтэст 20.0 сая төгрөгийн Зил-131 машин худалдан авсан, зураг, төсөв хүлээлцсэн болон тоног төхөөрөмж хүлээн авах комиссын актаар хүлээж аваагүй байхад 4 төсөл арга хэмжээний нийт 32.9 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчийн дансанд бүрэн шилжүүлсэн,

Г) Ерөө сум аймгийн ОНХО-ын эх үүсвэрээс эрх шилжиж ирсэн 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хүүхдийн тоглоомын талбай”-н ажлын гүйцэтгэгч Бурхант орд ХХК-д зураг төсөв, техник хяналтын зардлын 0.4 сая төгрөгийг шилжүүлсэн, мөн сумын хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлсэн 8.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй



"Ерөө сумын сургуулийн 90 жилийн ойд зориулсан хөшөө босгох " ажлын гүйцэтгэгчид санхүүжилтийг шилжүүлсэн боловч гэрээний хугацаанд уг ажлыг гүйцэтгэгчээс хүлээн аваагүй байна.

## 7.2.6 Орон нутгийн хөгжлийн сангийн талаар:

2017 онд Сэлэнгэ аймгийн ОНХС-д оны эхний үлдэгдлээс 134.5 сая төгрөгийн, туслах үйл ажиллагааны орлогоос 13.5 сая төгрөгийг, улсын төсвөөс 2,139.6 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, нийт 2,287.6 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэн, 70.9 хувийг буюу 1,516.4 сая төгрөгийг сумдын ОНХС-д, 29.1 хувийг буюу 674.2 сая төгрөгийг аймгийн ОНХС-аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтэд зарцуулж, оны эцэст 97.0 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Тайлант онд аймгийн ОНХС-д 118.6 сая төгрөгийн төсөвтэй 2 ажлыг шилжих хөрөнгө оруулалтаар, 585.6 сая төгрөгийн төсөвтэй 6 ажлыг шинээр эхлэх хөрөнгө оруулалтаар, 53.5 сая төгрөгийн төсөвтэй 2 ажлыг төсөл, арга хэмжээний зардлаар нийт 757.7 сая төгрөгийн 10 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг баталж, 674.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. ОНХС-ийн орлогын шилжүүлгээс 17 сумдад 1,516.4 сая төгрөгийг хувиарилан баталж, санхүүжилтийг бүрэн олгосон байна.

А) Аудитаар төсөвт өртгийг хувааж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан, техник хяналтыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлээгүй, комиссын актаар төсөл, хөтөлбөрийг хүлээн аваагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон, гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэгчээс хөрөнгө оруулалтын ажлыг хүлээн аваагүй зэрэг 152.0 сая төгрөгийн материаллаг алдаа, зөрчил илэрсэн байна. /Алдаа зөрчлийн дэлгэрэнгүйг хавсралт № 10-д үзүүлэв /Тухайлбал:

- Сүхбаатар сумын ИТХ-ын 2017 оны 28 дугаар тогтоолоор ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалтыг батлахдаа "Орхоны 6-р багт байрлах цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт" гэх нэг төсөл, арга хэмжээг тохижилтын ажилд 80.0 сая төгрөгөөр, ногоон байгууламжийн ажилд 30.0 сая төгрөгөөр тус тусад нь буюу төсөвт өртгийг хувааж баталснаас гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулж, уг ажлыг 109.9 сая төгрөгөөр гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн,
- Аймгийн ОНХС-д батлагдсан баяр наадмын зардлын төсвөөс шагайн харвааны салбар хороонд олгосон 1.6 сая төгрөгийн зардлын гүйцэтгэлийн тайланг гаргаж, холбогдох анхан шатны баримтыг бүрдүүлээгүй,
- Хушаат ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн 3 төсөл, арга хэмжээний ажлыг комисс хүлээн авч акт үйлдээгүй байхад 27.5 сая төгрөгийн үлдэгдэл санхүүжилтийг гүйцэтгэгчид бүрэн шилжүүлсэн байна.
- Баруунбүрэн сумын ОНХС-аар хийгдсэн 14.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Сумын төвд камер тавих" ажлыг "Орхон нүнжиг" ХХК-аар гүйцэтгүүлэхдээ эцсийн санхүүжилт 40%-ийг комисс хүлээж авсаны дараа шилжүүлэхээр гэрээнд заасан ч комисс хүлээж аваагүй байхад 71.1 %-ийн санхүүжилт олгож, 11.1 хувиар буюу 1.6 сая төгрөгийн санхүүжилт илүү олгосон,
- Алтанбулаг сумын ИТХ-ын тогтоолоор ОНХС-аар хийгдсэн 1, 2-р багийн "Жишиг гудамж" төслийн арга хэмжээний зардалд нийт 11.3 сая төгрөгийг иргэн, нөхөрлөлөөс блок худалдан авахад зарцуулсан байна. 1-р багийн 10, 2-р багийн 8 өрхтэй багийн дарга нар гэрээ байгуулж блок олгосон боловч өрхүүд жишиг гудамж төслийн дагуу хашаагаа блокоор өрөөгүй, 1-р багт блок нийлүүлэхээр гэрээ байгуулсан "Багацоорхой хоршоо" нь гэрээний хугацааг хэтрүүлж блок нийлүүлсэн байна.

**Найм:ТЕЗ-ийн тайланд нэгтгэгдсэн төсөл, сангийн талаар**

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сум хөгжүүлэх сангийн 17, аймаг хөгжүүлэх сангийн 1 нийт 18 сангийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

### **8.1 Төсөл, сангуудын санхүүгийн тайланд илэрсэн алдаа, зөрчлийн талаар:**

Төсвийн төвлөрүүлэн болон ерөнхийлөн захирагчийн түвшинд хийсэн аудитаар төсөл, сангийн данстай холбоотой 41.4 сая төгрөгийн материаллаг, 74.2 сая төгрөгийн материаллаг бус зэрэг нийт 115.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнээс аудитын явцад 83.8 сая төгрөгийн алдааг залруулж, 5.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 36.8 сая төгрөгийн зөрчилд аудитын зөвлөмж өгөв. */Алдаа зөрчлийн дэлгэрэнгүйг хавсралт № 11, 12-3-д үзүүлэв /*

Аудитаар санхүүгийн тайланд авлагын үлдэгдлийг анхан шатны баримтаас зөрүүтэй илэрхийлсэн, урьд оноос шилжин ирсэн өглөгийг барагдуулаагүй зэрэг материаллаг алдаа зөрчил илэрсэн байна. Үүнд:

- *Хушаат, Шаамар сумдын сум хөгжүүлэх сангийн санхүүгийн тайлан дахь зээлийн авлагын дүн нь хариуцсан мэргэжилтний дэлгэрэнгүй бүртгэлээрх авлагын дүнгээс 27.5 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан,*
- *Сүхбаатар сумын сум хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланд урьд оноос шилжин ирсэн 0.7 сая төгрөгийн авлага, Зүүнбүрэн, Сүхбаатар сум, Хушаат, Баянгол сумдууд зээл авсан иргэдээс бэлэн мөнгөний шимтгэлд суутган тооцсон, тодорхойгүй зэрэг 11.2 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг барагдуулаагүй байна.*

### **Ес. Аймаг, сумын орон нутгийн төсвийн байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар:**

Орон нутгийн төсвийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 4,425.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс аудитын явцад 2,264.3 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 7.8 сая төгрөгийн зөрчилд нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоон, 542.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 1,611.1 сая төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэв. */Алдаа, зөрчлийн дэлгэрэнгүйг хавсралт №12-1 т үзүүлэв /*

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2017 оны А/134 дугаар тушаалаар 5 сумын ЗДТГ-ын 2017 оны санхүүгийн тайланд итгэл үзүүлж, “Зөрчилгүй” санал-дүгнэлт өгөгдсөн бол 12 сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд гурвалсан гэрээний дагуу “Мэдээлэл аудит” ХХК-ийн Сэлэнгэ салбар, “Далайван аудит” ХХК-ийн Дархан салбар, “Дундманхайдай аудит” ХХК, “ЦЭСБ аудит” зэрэг ХХК-иуд, 17 сумдын ТЕЗ-ийн санхүүгийн тайлан, 34 төсвийн шууд захирагчийн, аймаг, сумдын орон нутгийн ерөнхий орлогын 18, зардлын 20 дансдын зэрэг 89 санхүүгийн тайланд Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар аудит хийж, 46 дүгнэлт гаргав. Үүнээс аймаг, сумдын орон нутгийн ерөнхий орлогын 18, зардлын 20 дансдын санхүүгийн тайлан, сумдын ИТХ-ын 17 санхүүгийн тайлан зэрэг 55 санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулан дүнг аймаг, сумдын төсвийн захирагчийн аудитын дүгнэлтэд нэгтгэсэн болно.

Төсвийн шууд захирагч нарын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 29 байгууллагыг хамруулж, 24 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт, 5 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

Сумдын төсвийн төвлөрүүлэн захирагч нарын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 12 сумын нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт, Хүдэр, Хушаат, Орхонтуул, Шаамар, Ерөө сумдын нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгөв.

*/Дүгнэлтийн хэлбэрийг хавсралт №15.2-д дэлгэрэнгүй үзүүлэв/*

**Арав. Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих төсвийн байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар:**

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайланд улсын төсвийн тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг ерөнхий боловсролын сургууль 35, хүүхдийн цэцэрлэг 38, соёлын төв 19, соёлын ордон, дуу бүжгийн чуулга 3, номын сан 2, орон нутгийн музей 1, биеийн тамир спорт хороо 7, хүүхдийн байгууллага 2, ГХБХБГ 1, ЭМТ 20, өрхийн ЭМТ 7 зэрэг нийт 135 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1-д “Аймаг, Нийслэлийн Засаг дарга Засгийн газрын дараах чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлнэ” гэж заасан. Үүнд:

- *Сургуулийн өмнөх боловсрол*
- *Ерөнхий боловсрол*
- *Соёлын үйлчилгээ*
- *Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ*
- *Газрын харилцаа, кадастр*
- *Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ*
- *Нийтийн биеийн тамир*

Үүний дагуу ЭМС, ХНХС, БХБС, БСШУС-ын батлагдсан төсвөөс тусгай зориулалтын шилжүүлгээр 2017 онд улсын төсвөөс нийт 46,644.5 сая төгрөгийн санхүүжилт авах төлөвлөгөөтэйгээс 46,644.5 сая төгрөгийн санхүүжилтийг авсан байна. Өөрийн орлогоос 124.5 сая төгрөгийг төвлөрүүлэхээс 117.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, нийт зардлын гүйцэтгэлээр 46,732.8 сая төгрөгийг захиран зарцуулж, зарлагын гүйцэтгэл 99.9 хувьтай тайлагнагдсан байна.

Улсын төсвийн тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,738.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс аудитын явцад 1,408.0 сая төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 39.3 сая төгрөгийн зөрчилд нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоон, 54.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 1,236.2 сая төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүллээ. /Алдаа, зөрчлийн дэлгэрэнгүйг хавсралт № 12-2 т үзүүлэв /

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжүүдийг холбогдох байгууллагын удирдлагууд хүлээн зөвшөөрсөн хариу ирүүлсэн болно.

Тусгай шилжүүлгийн 67 байгууллагын санхүүгийн тайланд гурвалсан гэрээний дагуу “Мэдээлэл аудит” ХХК-ийн Сэлэнгэ салбар, “Далайван аудит” ХХК-ийн Дархан салбар, “Дундманхайдай аудит” ХХК, “ЦЭСБ аудит” зэрэг ХХК-иуд, 68 байгууллагын санхүүгийн тайланд Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар аудит хийлээ. Үүнээс 106 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 23 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт тус тус өгөгдөж, 1 байгууллагын санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөхөөс татгалзаж, 5 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан байна. /Дүгнэлтийн хэлбэрийг хавсралт №15.2-д дэлгэрэнгүй үзүүлэв/

**Арван нэг. Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар:**

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 17 орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланг нэгтгэсэн байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь заалтын дагуу гурвалсан гэрээгээр “Мэдээлэл аудит” ХХК-ийн Сэлэнгэ салбар, “Далайван аудит” ХХК-ийн Дархан салбар, “Дундманхайдай аудит”

ХХК, “ЦЭСБ аудит” зэрэг хувийн аудитын компаниудаар орон нутгийн өмчит 11 аж ахуйн нэгжийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгүүлж, ТЕЗ-ийн санхүүгийн тайланд нэгтгүүлэв.

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь “Сэлэнгэ баялаг ирээдүй”, “Мандал хишиг хайрхан”, “Хүдэр тохижилт” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд аудит хийж, ТЕЗ-ийн тайланд нэгтгүүлэв.

“Тариалан эрхлэлтийг дэмжих техник дундын үйлчилгээний төв”, “Төгөлдөр ерөө”, “Үүрт бугант”, “Сэлэнгэ орон сууц” зэрэг 4 ОНӨААТҮГ –ууд нь тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй тул санхүүгийн тайланд аудит хийгдээгүй болно.

Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 1,440.0 сая төгрөгийн материаллаг бус, 1,156.3 сая төгрөгийн материаллаг зэрэг нийт 2,596.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна. Үүнээс аудитын явцад 1,177.7 сая төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж, 3.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, 438.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 976.8 сая төгрөгийн зөрчилд аудитын зөвлөмж өгөгдсөн байна. / Алдаа, зөрчлийн дэлгэрэнгүйг хавсралт № 12-4 т үзүүлэв /

Аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүдийг холбогдох аж ахуйн нэгжийн удирдлагууд хүлээн зөвшөөрсөн бөгөөд 2 аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 9 аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”, 2 аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд “Сөрөг санал дүгнэлт” тус тус өгөгдсөн байна.

#### **Арван хоёр: Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:**

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 1,800.7 сая төгрөгийн залруулагдах боломжгүй алдаа, зөрчил илэрсэн бөгөөд төсвийн шууд, төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланд тус бүрд нь зөвлөмж өгөгдсөн бөгөөд ерөнхийлөн захирагчийн түвшинд хийсэн аудитаар менежментийн захидлаар зөвлөмж хүргүүлэв.

#### **Арван гурав. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:**

**Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар анхаарал татахуйц дараах асуудал ажиглагдлаа. Үүнд:**

- Засгийн газрын 2010 оны 271 дугаар тогтоолоор үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10.0 сая төгрөг байхаар тогтоосон бол 2017 оны аймгийн баяр наадмын үйл ажиллагаанд аймгийн ОНХС-аас 50.0 сая төгрөг, Аймаг хөгжүүлэх сангаас 25.0 сая төгрөг зэрэг нийт 75.0 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, зарцуулсан байна. Уг тогтоолоор үндэсний их баяр наадамд амжилт үзүүлсэн бөх, уяач, харваачдад төсвөөс олгох бай шагналын жишиг хэмжээг, түрүүлсэн бөхөд 0.4 сая төгрөг, үзүүрлэсэн бөхөд 0.3 сая төгрөг, шөвгөрсөн бөхөд 0.2 сая төгрөг гэж баталсан байхад жишиг хэмжээнээс 0.1-0.6 сая төгрөгөөр хэтрүүлэн шагналыг баталж, олгосон байна.
- Тайлант онд аймгийн төсөвт 3 удаа, сумдын төсөвт тус бүр 3-6 удаа тодотгол хийгдсэн бөгөөд эдгээрийн дийлэнхийг Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан нөхцөл, шаардлага үүссэн тохиодолд бус төсвийн орлогын төлөвлөгөө давж биелэсэн хэмжээтэй уялдуулан төсвийн зарлагыг нэмэгдүүлж, төсөвт өөрчлөлт оруулсан байна. Цаашид Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан нөхцөл, шалтгаан үүссэн тохиолдолд төсвийн тодотгол хийж байхыг анхааруулж байна.
- Аймгийн хэмжээний сургууль, цэцэрлэгүүд шууд гэрээгээр худалдан авах босго үнээс давсан хүнсний материалын худалдан авах ажиллагааг шууд гэрээ байгуулах аргаар гүйцэтгэсэн байна. Иймд дээрх байгууллагуудын хүнсний материалын худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулах нөхцөл боломжийг бүрүүлэн, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу төсөв захирагч нарын



2017 онд хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээний хүрэх үр дүнг батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй харьцуулан тайлагнаагүй байна. Цаашид санхүүгийн тайлангийн тодруулгыг иж бүрэн хийж байх шаардлагатай .

- Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийг дараах 13 төрлийн арга хэмжээнд зарцуулсан байна.

/Хүснэгт №12/

( сая төгрөг)

д/д	Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт	Хуулгаар гарсан зардлын дүн	Эзлэх хувь
1	Спорт уралдаан тэмцээний зардал	89,847.7	19.8
2	Сургалт, зөвлөгөөн, хэлэлцүүлэг, чуулган	87,329.9	19.3
3	Сэлэнгэ аймгийн тухай сэтгүүл, каледарь хэвлүүлэх, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах зэрэг мэдээлэл сурталчилгааны зардалд	56,604.0	12.5
4	Гамшиг ослыг арилгахад	46,815.7	10.3
5	Нэг удаагийн тэтгэмж, дэмжлэг	44,320.0	9.8
6	Гадаад, дотоод зочин төлөөлөгч хүлээн авах, гадаад улсад хурал цуглаанд явах, албан ёсны айлчлал хийх	22,926.5	5.0
	Бусад улс орнуудад албан ёсны уулзалт сургалтын зардалд	16,364.0	3.7
7	Нэг удаагийн шагнал, урамшуулал	35,533.1	7.8
8	Баяр ёслолын зардалд	33,811.4	7.5
9	Ойн арга хэмжээнд	29,603.5	6.5
10	Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд	29,302.4	6.5
11	Бусад	24,855.7	5.5
12	Хөтөлбөр, арга хэмжээ аян	17,483.9	3.9
13	Зориулалт бус	7,998.4	1.8
	<b>Нийт дүн</b>	<b>452,948.4</b>	<b>1</b>

Өмнөх онд хийгдсэн аудитаар аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журам боловсруулж, баталж, мөрдөх зөвлөмж өгөгдөж байсан боловч зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байгаа нь Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт суларч, төсвийг үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулах эрсдэлийг үүсгэж байна. Тухайлбал, шагнал урамшуулал, нэг удаагийн тэтгэмжийн зардлыг харилцан адилгүй хэмжээгээр / аймгийн ЗДТГ-ын дэс түшмэл Б.Оюунд 3.5 сая төгрөгийн буцалтгүй тусламж олгосон бол ард иргэдэд тус бүр 200,0-300,0 мянган төгрөг гэх мэт / олгодог, гадаад, дотоодын уралдаан тэмцээн, бэлтгэл, сургуулилт, сургалтын төлбөр, амьжиргааны дэмжлэг зэргийг олгож буй шалгуур үзүүлэлт тодорхойгүй зэрэг байдал ажиглагдаж байна.

Зардлын гүйцэтгэлийн тайлангийн загвар маягт, заавал хянаж хүлээж авах баримт материалын жагсаалт зэргийг баталж, мөрдөхгүй байгаагаас зардлын гүйцэтгэлийн тайлан үйлддэггүй, анхан шатны баримт материалын үндсэн хувийг бус хуулбар тайлан, анхан шатны баримт зэргийг хүлээн авдаг зэрэг зөрчил нийтлэг байдлаар илэрч байна.

Цаашид аймгийн орон нутгийн онцлогт тохирсон Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах, тайлагнах журмыг баталж, мөрдөх шаардлагатай байна.

- Байгууллагын хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцаж байгаа албан тушаалтанд олгох нэмэгдэл, урамшууллын хэмжээг УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын 3.1 дэх “Нийтийн албаны удирдлага нь... албан тушаалынх нь цалингийн 40 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл урамшуулал олгох...” гэж заасан байдаг. Аудитын явцад хийсэн судалгаанаас харахад сумын ЗДТГ-ын бүтцэд ХАСХОМ мэдүүлэх үүрэг бүхий 5-15 төрийн албан хаагч байдаг бөгөөд ЭБАТ / эрх бүхий албан тушаалтан / -ны цалингийн нэмэгдлийг сар бүр үндсэн цалингийн 20.0-40.0 хувиар, аймгийн ЗДТГ-Т 10.0 хувиар тогтоосон бол сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга нарт 20-40 хувиар тус тус тогтоон, харилцан адилгүй олгож байна.

Иймээс аймгийн ТЕЗ-ийн зүгээс ажлын ачааллыг харгалзан уг нэмэгдлийн хувь, хэмжээг нэгдсэн журмаар тогтоон мөрдүүлэх нь зүйтэй юм. /Судалгааг хавсралт № 14 -д үзүүлэв /

- Аймгийн хэмжээнд 2017 оны жилийн эцсийн байдлаар 2011-2015 оны хооронд аймаг хөгжүүлэх сан, сум хөгжүүлэх сангаас иргэн, аж ахуйн нэгжид олгосон зээлийн хугацаа хэтрэлт 7,475.0 сая төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 594.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. / Судалгааг хавсралт № 15 -д үзүүлэв /
- Тайланд онд Засгийн газрын нөөц сан болон аймаг, сумдын ОНХС, ОНХО-ын эх үүсвэрээр нийт 445.3 сая төгрөгөөр тусгай зориулалтын 7, суудлын 14 нийт 19 автомашин худалдан авсан нь төсвийг хэмнэлттэй зарцуулах тухай УИХ-ын 2017 оны 29 дүгээр, ЗГ-ын 2014 оны 147 дугаар тогтоолуудтай нийцэхгүй байна. Цаашид төсвийн УИХ, ЗГ-аас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байх зарчмыг мөрдөж ажиллах нь зүйтэй байна. / Судалгааг хавсралт № 16 -д үзүүлэв /
- Аймгийн 17 сумын төр төсвийн байгууллагуудад 4 ОНӨААТҮГ, 9 хувийн компани, 4 аж ахуйн нэгж байгууллага халаалтын үйлчилгээ үзүүлж байна. /Хавсралт-15/ Судалгаанаас үзэхэд сумдад халаалтын үйлчилгээ үзүүлж буй хувийн компаниудыг сонгон шалгаруулалтгүйгээр шууд гэрээгээр ажиллуулж байгаа нь бусдад давуу байдал бий болгон, төсвийг үр ашиг, арвилан хэмнэлтгүйгээр зарцуулах боломжийг олгож байна. Тухайлбал: 2017 онд 168.0 сая төгрөгийн төсөвтэй Ерөө сумын халаалтын үйлчилгээг үзүүлэх гүйцэтгэгч “Монжим Трейд” ХХК-ийг шууд гэрээ байгуулах аргаар сонгон шалгаруулж, гүйцэтгүүлсэн байна. Мөн дээрх хувийн компаниуд нь орон нутгийн өмч хөрөнгө, техник, тоног төхөөрөмж ашиглан үйл ажиллагаа явуулж байхад холбогдох хуулийн дагуу түрээс төлүүлж, орлого төвлөрүүлэх ажил огт хийгдээгүй байна. Цаашид халаалтын үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгжийг ТБОНӨХБАҮХТ хуулийн дагуу нээлттэй, тэгш, шударга, өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, холбогдох хуулийн дагуу орон нутгийн өмч хөрөнгө ашигласны түрээсийн төлбөр төлүүлж байх нь зүйтэй юм. / Судалгааг хавсралт № 17 -д үзүүлэв /
- Аймгийн ИТХ болон Засаг даргын зүгээс орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул, бодлого, зохицуулалтын арга хэмжээ хангалтгүйгээс ихэнх аж ахуйн нэгжүүд алдагдалтай ажиллаж, өөрөө өөрийгөө санхүүжүүлж чадахгүй байдалд хүрсэн бөгөөд авлага, өр төлбөр их хэмжээгээр хуримтлагдсан байна. Иймээс 2018 онд дээрх аж ахуйн нэгж бүрийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, авлага, өр төлбөрт дүн шинжилгээ хийж, барагдуулах, орлого нэмэгдүүлж, зардлыг хэмнэх замаар үр ашигтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай байна.
- 2017 онд ажлаас үндэслэлгүй чөлөөлөгдсөн нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон 3 төрийн албан хаагчийн ажилгүй байсан хугацааны цалингийн нөхөн төлбөрт байгууллагын батлагдсан төсвөөс нийт 8.5 сая төгрөг төлж, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулах нөхцөлийг бүрдүүлжээ. Үүнд: Алтанбулаг сумын ЗДТГ-ын төсвөөс 1.9 сая, Цагааннуур сумын сургуулийн төсвөөс 5.2 сая, Баруунбүрэн сумын ЭМТ-ийн төсвөөс 1.4 сая төгрөгийн нөхөн төлбөрийг барагдуулсан байна. Цаашид дээрх зөрчлийг давтан гаргасан тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ” гэсэн заалтын дагуу төсөвт учруулсан хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх болно гэдгийг анхааруулж байна. Иймээс аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн зүгээс өөрийн багцад хамаарах төсвийн захирагчдад дээрх байдлын талаар анхааруулж ажиллах нь зүйтэй юм. / Судалгааг хавсралт № 18 -д үзүүлэв /

### **Арван дөрөв. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Орон нутгийн хөрөнгө оруулалтын үр

дүн"-д гүйцэтгэлийн аудит, "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны үр дүн"-д нийцлийн аудит тус тус хийх тул аймаг, сумдын ОНХО, ОНХС-ийн төлөвлөлт, худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтын талаарх болон бусад холбогдох баримт материалыг тус аудитаар нарийвчлан үзэх болно.

### **Арван тав. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:**

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 3,160.9 сая төгрөгийн материаллаг, 6,714.9 сая төгрөгийн материаллаг бус зэрэг нийт 9,875.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 4,923.9 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 50.7 сая төгрөгийн зөрчлийг холбогдох байгууллага, хувь хүмүүсээр төлүүлэх төлбөрийн акт тогтоон, 1,040.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 3,860. сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгуулах, цаашид давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв. /Алдаа, зөрчлийн нэгтгэлийг хавсралт № 12, 13-т үзүүлэв./

### **Арван зургаа. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт:**

ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 10 зөвлөмж өгснөөс тайлант хугацаанд 7 зөвлөмжийг хэрэгжүүлж, 3 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс алдаа, зөрчлүүд давтан гарсаар байна. Үүнд:

- *Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас авах авлаг, төлөх өр төлбөрт дүн шинжилгээ хийж, барагдуулах ажлыг зохион байгуулах, шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллагуудад хандан шийдвэрлүүлэх арга хэмжээ авах.*
- *ТЭДСантай техник тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн тооцоог нийлж, өр төлбөрийг данснаас хасуулах ажлыг зохион байгуулах,*
- *Засаг даргын нөөц хөрөнгийг журамд зааснаас бусад арга хэмжээнд зарцуулах зөрчлийг таслан зогсоох,*
- *Төсөвт байгууллагуудын цалингийн зардлын гүйцэтгэлд тавих төрийн сангийн хяналтыг сайжруулах, төсөвт зохицуулалт хийгдээгүй байхад зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулдаг зөрчлийг арилгуулах,*

### **Арван долоо. Аудитын зөвлөмж:**

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилд үндэслэн менежментийн захидлаар 7 зөвлөмж хүргүүлэв.

### **Арван найм. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:**

Аудитын явцад хийсэн горим, сорилын үр дүнд санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдтэй зөрчилдсөн материаллаг хэмжээний алдаа, зөрчилтэй асуудлууд илэрсэн тул Аудитын Олон улсын стандарт 705, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 203 дугаар тушаалаар баталсан "Санхүүгийн тайлангийн аудитын журам"-ын 2.20.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд дараах үндэслэлээр "Хязгаарлалттай" санал дүгнэлт өгч байна. Үүнд:

- *Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн Ерөө, Орхонтуул, Хүдэр, Хушаат, Шаамар сумдын төсвийн төвлөрүүлэн захирагч, орон нутгийн төсвийн 5 шууд захирагч, тусгай зориулалтын шилжүүлгийн 23 шууд захирагч, орон нутгийн өмчит 9 аж ахуйн нэгж зэрэг нийт 42 санхүүгийн тайланд "Хязгаарлалттай", "Сэлэнгэ үржлийн цөм сүрэг", "Мандал хишиг хайрхан" зэрэг 2 орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд "Сөрөг" дүгнэлт тус тус өгөгдсөн,*
- *Хушаат сумын ерөнхий боловсролын сургууль нь жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн цаглабарт хугацаанд аудитад хамруулаагүй бөгөөд санхүү, нягтлан бодох бүртгэлийн сүүлийн хагас жилийн баримт материалыг ирүүлээгүй,*

албан тушаалтнуудын зүгээс хяналт тавьдаггүйгээс хүнсний тайланг тухай бүр гаргаагүй, материалын үлдэгдлийг хасах утгаар тайлагнасан зэрэг нь тус байгууллагын санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлээгүй гэж үзэхэд хүргэн **санал дүгнэлт өгөхөөс татгалзаж**, төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд тус сургуулийн үр дүнгийн тайлангийн нийт зардал **501.0** сая төгрөгөөр алдаа, зөрчил тооцсон,

- Тайлант оны эцэст “Урсгал ус” ХХК, “Туулын хишиг”, “Сэлэнгэ-Энерго”, “Сэлэнгэ үйлчилгээ”, “Сэлэнгэ үржлийн цөм сүрэг”, “Сэлэнгэ- Зүүнхараа” “Хүдэр ойн анги”, “Мандал хишиг хайрхан”, “Хүдэр тохижилт” “Сэлэнгэ баялаг ирээдүй” зэрэг 10 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж нийт **902.8** сая төгрөгийн алдагдалтай тайлагнагдаж, өөрөө өөрийгөө санхүүжүүлэн ажиллаж чадахгүй байна.
- Орхонтуул сумын ЗДТГ, Сүхбаатар сумын 3-р сургууль, Ерөө сумын Бугант тосгоны сургууль, цэцэрлэг зэрэг төсвийн шууд захирагч, “Сэлэнгэ-Зүүнхараа” ОНӨААТҮГ нь жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгийн тооллого хийгээгүй,
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсөө захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитаар худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, орон тоо хэтрүүлсэн, анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан, авлага, өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй цалин, урамшууллыг давхардуулан олгосон гэх мэтчилэн нийт 2,551.9 сая төгрөгийн материаллаг алдаа, зөрчил илэрсэн байна.

### **Хязгаарлалттай санал дүгнэлт**

Дээрх алдаа, зөрчлийг эс тооцвол Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

### **АУДИТЫН ТАЙЛАНГ**

**ХЯНАСАН:** ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.БАТМӨНХ

**БЭЛТГЭСЭН:**

АХЛАХ АУДИТОР

С.БАТ-ЭРДЭНЭ

2018.04.20